

# БЭРС-3

ХӨРӨНГӨӨР  
БАТАЛГААЖСАН  
ҮНЭТ ЦААС

**Bers ABS**  
loyalty



**Golomt Capital**  
*Delivering diversity*

**UAF**  
ASSET MANAGEMENT

**COTA**  
AUDIT LLC

**\* MDSKhanLex**



**Bers ABS**  
Loyalty

MONGOLIAN STOCK EXCHANGE  
Үнэт цаасны танилцуулга  
2023  
БҮРТГЭВ-03

**ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД**

**Андеррайтер**



**“ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК**

+976-7012 1530

[www.golomtcapital.com](http://www.golomtcapital.com)

[info@golomtcapital.com](mailto:info@golomtcapital.com)

Улаанбаатар хот, Сүхбаатар, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плэйс оффисын барилга, 4 давхар, 403, 404

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгч**



**БЭРС ФИНАНС**

**Бэрс Финанс ББСБ ХХК**

+976 7712 2020

[www.bersfinance.mn](http://www.bersfinance.mn)

[info@bersfinance.mn](mailto:info@bersfinance.mn)

Улаанбаатар хот, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706тоот

**Зээлийн шинжилгээ гаргагч**



**“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ” ХХК**

+976-77233030

[cptaaudit.mn](http://cptaaudit.mn)

[info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 45А байр Оршил төв 5 давхар 501 тоот

**Хуулийн фирм**



**“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН**

[info@mdsa.mn](mailto:info@mdsa.mn)

+ 976-(11) 330048

[www.mdsa.mn](http://www.mdsa.mn)

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Централ Тауэр, 13 давхар, 1301 тоот

**Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч**



**“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХХК**


[info@uaf.mn](mailto:info@uaf.mn)

+ 976-7012 2346

[www.uaf.mn](http://www.uaf.mn)

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 10 давхар, 1005 тоот





**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД**

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох дүрэм, журмын дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргаж байгаа болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүрийн 100,000 төгрөгийн үнийн дүн бүхий 150,000 ширхэг автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж дээр гарган олон нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ БОЛОН АЛИВАА ЭРСДЭЛИЙГ СЭХ БОЛОН МХБ ХАРИУЦАХГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ.**

**ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Лоялти-ТЭК"-ХХК-болон Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК-д хандаж тодруулна уу.







**НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР**

<b>Нэр томьёо</b>	<b>Тайлбар</b>
Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны зах зээлд арилжихаар санал болгож Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Үнэт цаасаа бүртгүүлсэн этгээд.
Үүсгэн байгуулагч	Компанийг үүсгэн байгуулсан Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуульд заасан бол гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн.
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас буюу энэхүү танилцуулгад заасан ирээдүйд олох зээлийн орлогоор хөрөнгийн багц бүрдүүлэн тусгай зориулалтын компанид шилжүүлэх замаар үнэт цаасжуулсан санхүүгийн хэрэгсэл.
Андеррайтер	Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч.
Тусгай зориулалтын компани	Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани.
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд.
Үйлчилгээ үзүүлэгч	Үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээд.
Зээлийн шинжилгээ гаргагч	Хөрөнгийн багц дахь зээлийн дансдад тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлт хангагдсан эсэхэд дүгнэлт гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд.
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах болон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан үүрэг бүхий хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд.
Хууль зүйн дүгнэлт гаргагч	Хөрөнгийн багц дахь зээлийн дансдад тавигдах хуулийн шалгуур үзүүлэлт хангагдсан эсэх тухай хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан болон Хорооны журмаар тогтоосон агуулгын хүрээнд хууль зүйн дүгнэлт гаргагч үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий, СЗХ-д бүртгэлтэй хуулийн этгээд.
Үнэт цаасны танилцуулга	Хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, үнэт цаасны захиалга авах, худалдах зорилгоор холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу бэлтгэж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлсэн танилцуулга, баримт бичгийн бүрдэл.
Хөрөнгийн багц	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр.
Анхдагч зах зээлийн арилжаа	Үнэт цаас гаргагч хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаа нийтэд санал болгох замаар анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх арилжих үйл ажиллагаа.
Хоёрдогч зах зээлийн арилжаа	Үнэт цаасны анхдагч зах зээлд гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг дахин арилжих үйл ажиллагаа.








**ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР**

Товч үг	Тайлбар
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
СЭХ эсхүл Хороо	Санхүүгийн Зохицуулах Хороо
МХБ эсхүл Бирж	Монголын Хөрөнгийн Бирж
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТЗК	Тусгай зориулалтын компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХИУ	Хөрөнгө итгэмжлэн удирдагч
АҮГ	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
ӨОХ	Өр орлогын харьцаа
ЗҮХ	Зээл үнэлгээний харьцаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага





**Bers ABS**  
loyalty




Үнэт цаасны танилцуулга

2023 - 25

**БҮРТГЭВ-03**

**АГУУЛГА**

<b>ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД.....</b>	<b>2</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД .....</b>	<b>3</b>
<b>НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР.....</b>	<b>4</b>
<b>ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР .....</b>	<b>5</b>
<b>АГУУЛГА .....</b>	<b>6</b>
<b>ХҮСНЭГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>8</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>9</b>
<b>ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....</b>	<b>9</b>
<b>СХЕМИЙН ЖАГСААЛТ.....</b>	<b>9</b>
<b>1. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>11</b>
1.1. ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ .....	11
1.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ .....	12
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ.....	12
1.4. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД ХБУЦ-НЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ.....	13
<b>2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ .....</b>	<b>16</b>
2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ .....	16
2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ .....	17
2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	19
2.3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал.....	19
2.3.2. Төлөөлөн удирдах зөвлөл .....	19
2.3.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц.....	20
2.3.4. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан баланс .....	22
2.3.5. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл.....	23
<b>3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ .....</b>	<b>28</b>
3.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ .....	28
3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГЭРЭЭНҮҮД.....	32
3.3. ХӨРӨНГИЙН БАГЦ .....	35
3.3.1. Хөрөнгийн багцад тавих санхүүгийн шалгуур үзүүлэлт .....	35
3.3.2. Хөрөнгийн багцад тавих хуулийн шалгуур үзүүлэлт.....	36
3.3.3. Зээлийн багцын голлох мэдээлэл .....	37
3.4. ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙН БАГЦЫН ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН .....	39
3.5. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН .....	39
<b>4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ.....</b>	<b>41</b>
4.1. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ .....	41
4.2. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ БОЛОН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ҮЙЛ	
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ .....	43
4.3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УДИРДЛАГЫН БҮТЦИЙН ТУХАЙ .....	44
4.4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС .....	49
4.5. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ.....	53
4.6. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА БОЛОН САЛБАРТ	
ЭЗЛЭХ ХУВЬ.....	59
<b>5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ.....</b>	<b>62</b>
<b>6. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ.....</b>	<b>67</b>
6.1. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА.....	67
6.2. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ.....	69
6.3. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	71
6.4. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ПРОГРАММ, ХАНГАМЖ,	
СИСТЕМИЙН ТУХАЙ.....	74
6.5. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨХГҮЙ НӨХЦӨЛД АВАХ	
АРГА ХЭМЖЭЭ .....	75





**Bers ABS**  
loyalty

БҮРТГЭВ-03

Үнэт цаасны танилцуулга



<b>7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН.....</b>	<b>77</b>
7.1. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ .....	77
7.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ.....	81
7.3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ.....	86
7.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ .....	89
<b>8. ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН .....</b>	<b>95</b>
8.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	95
8.2. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	97
8.3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ БОЛОН ХӨРӨНГИЙН БАГЦТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	98
8.4. БЭРС-3 ХБҮЦ-ТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ:.....	99
8.5. ТЗК ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ.....	101
<b>9. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ .....</b>	<b>103</b>
9.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ.....	103
9.1.1. Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар .....	104
9.1.2. Албан татвар .....	105
9.1.3. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа.....	105
9.1.4. Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр .....	105
9.1.5. Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг .....	105
9.1.6. Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг .....	105
9.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАНИЛЦУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ.....	107
9.3. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА.....	110
<b>10. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД.....</b>	<b>116</b>
10.1. АНДЕРРАЙТЕР .....	116
10.2. ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ .....	117
10.3. ХУУЛИЙН ФИРМ .....	118
10.4. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ .....	119
10.5. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН ХОЛБОО ХАМААРАЛТАЙ ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	120
<b>11. ХАВСРАЛТ .....</b>	<b>121</b>







**Bers ABS**  
loyalty

MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга  
2023.10.25

БҮРТГЭВ-03

**ХҮСНЭГИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1: Үнэт цаасны ерөнхий нөхцөл.....	11
Хүснэгт 2: ХБҮЦ төлбөрийн хуваарь, сая төгрөгөөр.....	13
Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл.....	16
Хүснэгт 4: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл.....	17
Хүснэгт 5: Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл.....	17
Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, танилцуулга.....	21
Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс, төгрөгөөр.....	22
Хүснэгт 8: Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны хугацаан дахь мөнгөн урсгалын төсөөлөл, сая төгрөгөөр.....	24
Хүснэгт 9: ТЗК-ийн Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр.....	25
Хүснэгт 10: ТЗК-ийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр.....	25
Хүснэгт 11: ТЗК-ийн мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр.....	26
Хүснэгт 12: ХБҮЦ үнэт цаасжуулах процесст оролцогч талууд.....	30
Хүснэгт 13: Үнэт цаас гаргагчийн оролцогч талуудтай хийсэн гэрээ.....	32
Хүснэгт 14: Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт.....	37
Хүснэгт 15: Фидуци бүхий зээлийн багцын хугацааны задаргаа.....	38
Хүснэгт 16. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн талаарх мэдээлэл.....	43
Хүснэгт 17: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн толгой компанийн тухай.....	43
Хүснэгт 18. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны чиглэл.....	44
Хүснэгт 19: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүү байдлын тайлан, сая төгрөгөөр.....	53
Хүснэгт 20. Орлого, үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр.....	56
Хүснэгт 21: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гаргасан үнэт цаасны мэдээлэл.....	59
Хүснэгт 22. Үнэт цаас гаргагчийн зохистой харьцаа үзүүлэлтүүд.....	59
Хүснэгт 23: Үнэт цаас гаргагчийн салбарт эзлэх хувь.....	60
Хүснэгт 24: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл.....	67
Хүснэгт 25: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төрөл.....	79
Хүснэгт 26: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны давуу болон сул тал.....	80
Хүснэгт 27: Монгол улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд.....	81
Хүснэгт 28: Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар.....	83
Хүснэгт 29: Инфляцын төсөөлөл, хувиар.....	84
Хүснэгт 30: ББСБ салбарын зээлийн зээлдэгчийн ангилал.....	91
Хүснэгт 31. ББСБ салбарын зээлийн хэлбэрийн ангилал.....	91
Хүснэгт 32: Салбарын ашигт ажиллагааны харьцаа.....	93
Хүснэгт 33: ХБҮЦ гаргахтай холбоотой хууль, дүрэм журмууд.....	97
Хүснэгт 34: Үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээлэл түгээх нь.....	107
Хүснэгт 35: ХБҮЦ-ны хүрээнд учирч болзошгүй эрсдэлүүд.....	110





**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**


Зураг 1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн салбаруудын байршил ..... 44

**ГРАФИКИЙН ЖАГСААЛТ**

График 1: Үнэт цаасны хүүгийн харьцуулалт ..... 12  
 График 2: Фидуци бүхий зээлийн багцын задаргаа /үлдэгдэл дүнгээр/ ..... 37  
 График 3: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр зээл, сая төгрөгөөр ..... 54  
 График 4: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө, сая төгрөгөөр ..... 54  
 График 5: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багцын чанар ..... 55  
 График 6: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн чанаргүй зээлийн хувь ..... 55  
 График 7: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн жигнэсэн дундаж хүү ..... 55  
 График 8: Эх үүсвэрийн бүтэц, 2023Q3, сая төгрөгөөр ..... 56  
 График 9: Анхны үүрэг гүйцэтгэгчийн хүүгийн орлого, зардал, сая төгрөгөөр ..... 57  
 График 10: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ашигт ажиллагаа, сая төгрөгөөр ..... 57  
 График 11. Цэвэр ашиг, сая төгрөгөөр ..... 57  
 График 12: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ба салбарын харьцуулалт, 2023Q3 дүнгээр ..... 60  
 График 13: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөгжил, Монгол улс ..... 80  
 График 14: Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар ..... 82  
 График 15: Инфляцын түвшин, хувиар ..... 83  
 График 16: Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр ..... 84  
 График 17: Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллараар ..... 85  
 График 18: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөгөөр ..... 86  
 График 20: Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо ..... 87  
 График 19: Шинээр бүртгэсэн ХК ..... 87  
 График 21: ТОП-20 индекс ..... 87  
 График 22: Үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөгөөр ..... 88  
 График 23. Санхүүгийн салбарын бүтэц, 2022 он ..... 89  
 График 24: ББСБ салбарын тоо, харилцагчдын тоо /мянган хүнээр/ ..... 89  
 График 25: ББСБ салбарын хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр ..... 90  
 График 26: ББСБ салбарын нийт зээл, тэрбум төгрөгөөр ..... 91  
 График 27: ББСБ салбарт олгогдсон зээлийн хугацаа, сараар ..... 92  
 График 28: ББСБ салбарын эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр ..... 92  
 График 29: Хүүгийн орлого, зардал, цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр ..... 93

**СХЕМИЙН ЖАГСААЛТ**

Схем 1: Үнэт цаасжуулах процесс зураглал ..... 31  
 Схем 2: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт ..... 46  
 Схем 3: Поларис системийн үндсэн бизнес процесс ..... 52  
 Схем 4: ХБҮЦ-ны төлбөр цуглуулах зураглал ..... 62  
 Схем 5. ХБҮЦ-ны зураглал ..... 77  
 Схем 6. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө ..... 103  
 Схем 7. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар ..... 104



СЭХ ХӨД  
2023.12.22

МОНГОЛЫН  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023 25  
БҮРТГЭВ-03

# НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА







**1. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА**

**1.1. ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

Үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК нь автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан, нийт 15.0 тэрбум төгрөгтэй тэнцэх доорх нөхцөл бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож байна.

**Хүснэгт 1: Үнэт цаасны ерөнхий нөхцөл**

Үнэт цаас гаргагч	Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Бэрс Финанс ББСБ ХХК
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын Хөрөнгийн Бирж
Үнэт цаасны төрөл	Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны нэр	“Бэрс-3” ХБҮЦ
Нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Санал болгож буй тоо ширхэг	150,000 ширхэг
Татан төвлөрүүлэх нийт дүн	15,000,000,000 төгрөг хүртэл
Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа	2023.12 сар
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	Жилийн 18.0%
Үнэт цаасны хүү төлөх хугацаа	Улирал тутам
Үнэт цаасны үндсэн төлбөр төлөх хугацаа	Хагас жил тутам
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Үнэт цаасны зарцуулалт	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн багцыг худалдан авах санхүүжилт
Барьцаа	Автомашины фидуци бүхий зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс
Үнэт цаас төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу Хөрөнгө оруулагч нь үнэт цаасны хүүгийн орлогоос 5 хувийн албан татварыг суутгуулна.

**Хүү тооцох нөхцөл**

Хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн жилийн 365 хоноогоор тооцно.



## 1.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ


Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн түвшнийг тодорхойлохдоо Монгол банкнаас зарласан бодлогын хүү, зах зээл дэх ижил төстэй өрийн хэрэгслийн хүүгийн түвшин, үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасны эрсдэлийн хүчин зүйл зэрэгт үндэслэж тооцсон.

2023 оны 11 дүгээр сарын байдлаар Монгол банкнаас зарласан бодлогын хүүгийн түвшин 13.0% бөгөөд улсын инфляц 9.0% байна. Монгол банкны статистикийн дагуу арилжааны банкнуудын шинээр татсан төгрөгийн 10-12 сарын хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 12.78 хувь байгаа ба инфляцын түвшин 9.0% байхад хадгаламжийн нэрлэсэн хүүгийн түвшинд 3.78 хувиар өндөр байна.

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Бэрс-3 ХБҮЦ нь 18.0 хувийн хүүгийн түвшинд буюу шинээр татаж буй төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүүтэй харьцуулахад нэрлэсэн хүүгийн түвшинд 5.22 хувиар өндөр өгөөжтэй байна.

2023 оны 11 дүгээр сарын байдлаарх системийн томоохон банкнуудын 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн дундаж хүү, түүнчлэн 2023 онд Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн бусад нээлттэй үнэт цаасны санал болгосон хүүтэй харьцуулан доор харуулав.

### График 1: Үнэт цаасны хүү болон арилжааны банкны 12 сарын хугацаатай хадгаламжийн хүүгийн харьцуулалт



Эх сурвалж: Арилжааны банкнууд болон МХБ-ийн цахим хуудас

## 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны төлбөрийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг нийт 19,393,810,877.39 төгрөгийн дүн бүхий зээлийн багцын эргэн төлөлтийн мөнгөн урсгалаар төлнө. Ийнхүү ХБҮЦ нээлттэй арилжаалагдаж буй үед төлөгдсөн зээлийн мөнгөн дүн ХБҮЦ-ийн үндсэн болон хүүгийн төлбөр, бусад гэрээт төлбөрт ашиглагдана.

Тус багц нь ирээдүйд зээлийн гэрээгээр хүлээсэн эргэн төлөх хуваарийн дагуу эргэн төлөгдөх бөгөөд хуваарь хэтэрч төлөгдөх, хугацаанаас өмнө илүү дүнгээр төлөх зэрэг шалгуур хангахгүй гэж үзэх нөхцөл гарсан үед хөрөнгө итгэмжлэн удирдагч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан зээлээр солих, шинээр зээлийн багц нэмж худалдан авах зэргээр мөнгөн урсгалын тооцоололд өөрчлөлт оруулна. Үнэт цаасны хуваарьт төлбөр төлөх өдөр үнэт цаас гаргагчийг бүрэн биелүүлэх нөхцөл, боломжийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч тооцож хэрэгжүүлнэ.



ТЗК-ийн санал болгож буй үнэт цаас нь:

- Жилийн 18.0 хувийн хүүтэй;
- Улирал тутам хүү төлөх
- Үндсэн төлбөрийг хагас жил тутам төлөх нөхцөлтэй бөгөөд ХБҮЦ-ны эргэн төлөх төлөвлөгөөний задаргааг доор хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 2: ХБҮЦ төлбөрийн хуваарь, сая төгрөгөөр**

	У1	У2	У3	У4	У5	У6	У7	У8
Үнэт цаас эзэмшигчдэд төлөх хүү	675.00	675.00	506.25	506.25	337.50	337.50	168.75	168.75
Татварын дараах хүү	641.25	641.25	480.94	480.94	320.63	320.63	160.31	160.31
Төлөгдөх үндсэн төлбөр	-	3,750.00	-	3,750.00	-	3,750.00	-	3,750.00
<b>Төлөгдөх нийт дүн</b>	<b>675.00</b>	<b>4,425.00</b>	<b>506.25</b>	<b>4,256.25</b>	<b>337.50</b>	<b>4,087.50</b>	<b>168.75</b>	<b>3,918.75</b>
<b>ХБҮЦ үлдэгдэл</b>	<b>15,000.00</b>	<b>11,250.00</b>	<b>11,250.00</b>	<b>7,500.00</b>	<b>7,500.00</b>	<b>3,750.00</b>	<b>3,750.00</b>	<b>-</b>

Эх сурвалж: Андеррайтер, ХИУ-ийн тооцоолол

**Анхаарах:** Хөрөнгө оруулагчийн эргэн төлөлтөөс авах үндсэн болон хүүгийн төлбөрийг түүний эзэмшиж буй үнэт цаасны тоо ширхэг, дүнгээс тооцно.

**1.4. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД ХБҮЦ-НЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-аас баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-д ХБҮЦ-ны төлбөрийг дараах дарааллаар төлөхөөр тусгажээ.


1. ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч ҮЦТХТ-өөс хүлээн авна.
2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч ҮЦТХТ-өөс ирсэн үнэт цаас эзэмшигчдийн нэрсийн дагуу холбогдох тооцооллыг хийсний дагуу ТЗК нь шилжүүлнэ. ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг гаргаснаас хойш үнэт цаас эзэмшигч солигдсон тохиолдолд төлбөрийг өмнөх үнэт цаас эзэмшигч хүлээж авна.
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дээрх жагсаалтад багтсан нэрсийн дагуу тасалбар болгон эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, төлбөрийн хуваарийн тооцооллыг хийж үнэт цаас эзэмшигч тус бүрээр төлөгдөх төлбөрийн тооцооллыг хийж, баталгаажуулсан тооцоог ҮЦТХТ рүү хүргүүлнэ.
4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тооцоог татварын өмнөх болон дараах байдлаар тус тус гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ рүү шилжүүлж, үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.
5. ТЗК нь ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ дэх ТЗК-ийн үнэт цаасны дансанд төлбөр төлөх өдрөөс ажлын 1 хоногийн өмнө байршуулж, ҮЦТХТ нь тооцоололд заасны дагуу үнэт цаас эзэмшигч тус бүрд хуваарьт өдөр төлбөрийг шилжүүлнэ.
6. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарь, үнийн дүнгийн тооцоолол дээр алдсан, мэдээлэл буруу бичсэн зэрэг алдаа гарсан бол нэн даруй алдааг засах арга хэмжээ авна. Хэрэв уг алдаанаас болж үнэт цаас эзэмшигч, ТЗК болон бусад этгээдэд хохирол учирсан бол хохирлыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.







**Bers ABS**  
loyalty



**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг буцаан худалдан авах нөхцөл**

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан дараах үндэслэлээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд ХБҮЦ-ыг буцаан худалдан авна. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18.2.3-д заасны дагуу Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасны дагуу Хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцсон;

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан авах, 2023 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон нийт 19,393,810,877.39 төгрөгийн автомашины фидуци бүхий зээлийн багцаас орох мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд уг үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргуулаагүй, мөн эрх бүхий мэргэжлийн байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгоогүй болно.



СЭХ




**ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ (ТЗК)-ИЙН  
ТУХАЙ**





**Bers ABS**  
Loyalty



**2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ**

**БҮРТГЭВ-03**

**2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ**

Үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Компанийн тухай хуулийн 12.1, 13.1 дугаар зүйл болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11.1, 12.3, 12.4 дүгээр зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан.

Хуульд заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах “тусгай зориулалтын компани”-ийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно.

Иймд “Бэрс Финанс ББСБ” ХХК нь 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн №23/01а/35 тоот хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийг үүсгэн байгуулж, 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн 682 тоот тогтоолоор олгогдсон ТЗ 315/61 дугаартай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.1 болон 12.5 дүгээр зүйлийн дагуу **“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК** болон өөрчлөгдөж, холбогдох өөрчлөлтийг улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн.

**Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл**

<b>Үнэт цаас гаргагч</b>	“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК
<b>Хувьцаа эзэмшигч</b>	“Бэрс Финанс ББСБ” ХХК, <b>/100%/</b>
<b>Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо</b>	2023.09.21
<b>ТЗК тусгай зөвшөөрөл авсан огноо</b>	2023.11.08
<b>Регистрийн дугаар</b>	8416052
<b>Улсын бүртгэлийн дугаар</b>	9011856259
<b>Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл</b>	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх
<b>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар</b>	ТЗ 315/61
<b>Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ</b>	1,000,000 (нэг сая төгрөг)
<b>Оршин буй хаяг</b>	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот
<b>Утас</b>	+976 9911 9632








**2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ**

БҮРТГЭЛЭГ-03



**Үүсгэн байгуулагч:** “Бэрс финанс ББСБ” ХХК нь үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1000 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан энгийн хувьцааг 100% эзэмшиж байна. Бэрс Финанс ББСБ ХХК нь 2017 оны 5 дугаар сарын 18-нд үүсгэн байгуулагдаж, ББСБ-ын зээлийн болон факторингийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Тус компани нь өдгөө 21 салбар, 80 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

**Хүснэгт 4: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл**

Нэр:	БЭРС ФИНАНС ББСБ ХХК
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот
Улсын бүртгэлийн дугаар:	9015005096
Регистрийн дугаар:	6186858
Хувьцаа эзэмшигч:	Бэрс Капитал ХХК \100%\
Гүйцэтгэх захирал:	С.Отгонбат
Имэйл:	info@bersfinance.mn
Утас:	(976) 7712-2020
Вэбсайт:	www.bersfinance.mn

**Эцсийн өмчлөгч:** “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн 100% хувьцаа буюу нэг бүр нь 6,090,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1000 ширхэг хувьцааг Бэрс Капитал ХХК эзэмшдэг. **Бэрс Капитал ХХК нь** 2015 оны 1-р сарын 19-нд байгуулагдсан ба уг компанийг иргэн Самдан овогтой Отгонбат 100% эзэмшиж байна.

**Хүснэгт 5: “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэл**

Нэр:	БЭРС КАПИТАЛ ХХК
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол, 3-р хороо, 2 хороолол, Замчдын гудамж, 18-2 тоот
Улсын бүртгэлийн дугаар:	9011526089
Регистрийн дугаар:	5922178
Хувьцаа эзэмшигч:	С.Отгонбат \100%\
Үйл ажиллагааны чиглэл:	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа

Харин “Тусгай зориулалтын компани” нь зөвхөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготой байх бөгөөд Хорооны зөвшөөрөлгүйгээр хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх эрхгүй болно.

Түүнчлэн хуульд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглоно.






**Bers ABS**  
loyalty

Түүнчлэн үнэт цаас гаргагчийн холбогдох этгээд, толгой болон зэргэлдээ компанийн мэдээлэл нь дараах бөгөөд улсын бүртгэлд бүртгэгдсэн мэдээллээр эцсийн өмчлөгч нь иргэн С.Отгонбат юм.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:**

**С.ОТГОНБАТ**





## 2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.12.5 дугаар заалтад тусгасны дагуу ТЗК нь хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах хориотой тул үндсэн ажилтангүй болно.

ТЗК нь хөрөнгө худалдаж авах, баталгаат үнэт цаас гаргах, хөрөнгө өмчлөх хөрөнгө удирдах болон бусад эрхийн хүрээнд хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ. Компанийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага, тэдгээрийн эдлэх эрх, үүрэг нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэм журмаар зохицуулагдана.

### 2.3.1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн дүрэмд тусгасны дагуу үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.


Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэгтэй холбоотой нэмэлт заалтыг ТЗК-ийн дүрэмд дурдаагүй байна.

### 2.3.2. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

**Компанийн дүрмийн 4-р хэсэгт тусгасан ТУЗ-ийн эрх мэдэл, хариуцлагын тухай голлох заалтуудыг танилцуулбал:**

- ТЗК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь **3** гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.
- ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр нөхөн сонгоно
- ТЗК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
  - ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
  - Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;
  - Компанийн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. (Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно);
  - Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих;
  - Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
  - Компанийн нэр дээр данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;







**Bers ABS**  
loyalty



Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах;

- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавих, хангуулах;
  - Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх;
  - ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.
- ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн дарга, эсхүл гишүүдийн олонхын санал, эсхүл хөрөнгө итгэмжлэн удирдагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно
  - ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн санал нэгтэй шийдвэрээр батлагдана.
  - ТУЗ-ийг төлөөлж, аливаа баримт бичигт ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна
  - ТУЗ болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6.1 хэсэгт заасан ХБҮЦ гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн Компани татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

### 2.3.3. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ

Үнэт цаас гаргагчийн 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын №23/26а/03 тоот шийдвэрийн дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар шийдвэрлэсэн ба ТУЗ нь дараах бүтэцтэй байна.

Түүнчлэн 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №23/26а/04 тоот тогтоолоор ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийг томилжээ. ТУЗ-ийн гишүүдийн боловсон хүчний тодорхойлолт болон бусад шаардлагатай мэдээллийг Хүснэгт 6 болон Хавсралт хэсэгт оруулав.





**ТУЗ-ийн дарга,  
энгийн гишүүн  
Я.Адьяахүү**

**Боловсрол:**

- Сайтама их сургууль, Япон – Төрийн удирдлага, магистр (1997-1998)
- МУИС-ЭЗС, Монгол – Банкны эдийн засагч, бакалавр (1987-1991)

**Ажлын туршлага:**

- Бэрс финанс ББСБ -Хөрөнгө оруулалтын газрын захирал (2023.09-одоог хүртэл)
- Бэрс финанс ББСБ – Санхүү бүртгэлийн газрын захирал (2020-2023.09)
- Нэткапитал ББСБ – Эрсдэлийн захирал, Дэд захирал (2018-2020)
- Глашиер ассет ХОМК -Гүйцэтгэх захирал (2015-2017)
- Хас банк – Хэлтсийн захирал, Газрын захирал (2009-2015)
- Худалдаа хөгжлийн банк -Эдийн засагч, эрсдэлийн шинжээч, ДХА, Газрын ахлах (1998-2009)
- Зах зээлийн судлалын хүрээлэн – Судлаач (1992-1997)

**ТУЗ-ийн хараат  
бус гишүүн  
Д.Ганхүрэл**

**Боловсрол:**

- Нагояа их сургууль, Япон – Эрх зүйн докторант (2021-суралцаж байгаа)
- Чүо их сургууль, Япон – Эрх зүйн магистр (2018-2020)
- МУИС, Хууль зүйн сургууль – Эрх зүйн бакалавр (2012-2017)

**Ажлын туршлага:**

- МУИС-ийн Хууль зүйн сургууль – Багш (2020- одоог хүртэл)
- Накано Нозава хуулийн фирм – Хуульчийн туслах (2018-2020)
- MBS хуулийн нөхөрлөл – Өмгөөллийн туслах (2016-2017)

**ТУЗ-ийн хараат  
бус гишүүн  
Н.Мэнд-Амар**

**Боловсрол:**

- Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Монгол – Англи хэлний орчуулагч (2020- суралцаж байгаа)
- Отгонтэнгэр их сургууль, Монгол – Олон улсын эрх зүйч (2008-2012)

**Ажлын туршлага:**

- Монос групп ХХК – Хуулийн зөвлөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (2023 – одоог хүртэл)
- Өмгөөллийн Ди Би Энд Жи Ти Эе ХХН – Нөхөрлөлийн гишүүн хуульч (2019-2023.01)
- Жи Ти Эс Адвокатс ХХН – Хуульчийн туслах, хуульч (2012-2019)





**Bers ABS**  
Loyalty

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам:



Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11-р сарын 16-ны өдрийн 23/26а/07 дугаар тогтоолоор "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан бөгөөд журмаар ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ТУЗ гишүүнд тавигдах шаардлага, бүрэн эрх, үүрэг, ажиллах нөхцөл, хариуцлага зэргийг нарийвчлан тусгажээ.

Журамд зааснаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг гэрээний үндсэн дээр Захиргааны үйлчилгээ үзүүлэгч (ТЗК-ийн үүсгэн байгуулагч) гүйцэтгэнэ. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, гишүүдийн хүлээх үүрэг, бүрэн эрх, ажиллах зарчим, нөхцөл зэргийг дэлгэрэнгүй оруулж өгсөн байна. Журамд заасны дагуу ТУЗ-аас компанийн үйл ажиллагааг удирдах, хянах ажлын хүрээнд дагаж мөрдөх дараах журмуудыг баталж, мөрдөнө:

- ХБҮЦ-ны хөрөнгийн багцыг сонгох шалгуур үзүүлэлтийг батлах
- Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох солих тухай журам
- Хөрөнгө итгэмжлэн удирдах журам
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх тухай журам
- Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам
- Эрсдэл сонирхлын зөрчлийг илэрхийлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам.

#### 2.3.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН БАЛАНС

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч Бэрс Финанс ББСБ ХХК нь нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1000 ширхэг энгийн хувьцаа буюу 1,000,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд эхлэлтийн тайлан баланс дараах байдалтай байна.

#### Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс, төгрөгөөр

Хөрөнгө	2022	2023.09.30
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	-	1,000,000
<b>Нийт хөрөнгө</b>	<b>-</b>	<b>1,000,000</b>
Эх үүсвэр	2022	2023.09.30
Энгийн хувьцаа	-	1,000,000
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>-</b>	<b>1,000,000</b>

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, Үнэт цаас гаргагчийн дүрэм

2023 оны 09 сарын 30-ны өдрийн санхүүгийн тайлан буюу эхлэлтийн тайланд орлого, зарлага, ашиг огт тайлагнагдаагүй бөгөөд компани үүсгэн байгуулах 1,000,000 төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орох мөнгөн гүйлгээгээр бүртгэсэн байна.







**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

### 2.3.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцад багтсан зээлийн багцын үндсэн болон хүүгийн эргэн төлөлт, хугацаанаас өмнө төлөх, хугацаа хоцрох магадлал, цугларсан хөрөнгийг үр ашигтайгаар байршуулах зэрэг тохиолдлуудыг тооцон үзэж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараах таамаглалуудыг санхүүгийн тайлангийн төсөөлөлд ашигласан байна.

#### ХБҮЦ-НЫ ҮНДСЭН НӨХЦӨЛ:

❖ ХБҮЦ-ны хэмжээ:	❖ 15,000,000,000 төгрөг
❖ Хүүгийн хэмжээ:	❖ Жилийн 18.0%
❖ Хугацаа:	❖ 24 сар
❖ Үндсэн төлбөр төлөх давтамж:	❖ Хагас жил тутам
❖ Хүүгийн төлбөр төлөх давтамж:	❖ Улирал тутам

#### Санхүүгийн төсөөлөлд ашигласан таамаглалууд:

- ❖ Үнэт цаас гаргагч нь зөвхөн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулна;
- ❖ ТУЗ-ийн цалин гэрээний дагуу, тогтмол дүнтэй;
- ❖ Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр гэрээний дагуу, сар бүр тогтмол;
- ❖ Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл гэрээний дагуу, сар бүр тогтмол;
- ❖ Аудитын үйлчилгээний төлбөр жилд 1 удаа, гэрээний дагуу, тогтмол;
- ❖ Захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр гэрээний дагуу, сар бүр тогтмол;
- ❖ Зээлийн багцад багцалсан зээлийн дундаж хүү сарын 3.32%;
- ❖ Зээлийн багцад багцалсан зээлийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 36.44 сар;
- ❖ Зээлийн багцаас хуваарьт төлбөрөө урьдчилж төлөх магадлал 4.22%;
- ❖ Хуваарьт төлбөр хугацаа хэтрэх магадлал 10.05%;
- ❖ Өмнөх сарын хуваариас өмнө урьдчилж төлөгдсөн дүнгээр дараа сард нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шинээр багц худалдаж авах ба, шинээр худалдаж авч нэмэгдүүлсэн зээлээс мөн урьдчилж төлөгдөх магадлал тооцно;
- ❖ Үндсэн болон хүүгийн төлбөр хугацаа хэтэрсэн тохиолдолд тухайн дүнгийн дунджаар 72 хувь нь хуваарь хэтэрснээс хойш 31-60 хоногийн дотор төлөгдөнө;
- ❖ Үндсэн болон хүүгийн төлбөр хугацаа хэтэрсэн тохиолдолд төлөгдөөгүй үлдсэн 28 хувь нь хуваарь хэтэрснээс хойш 61-90 хоногийн дотор төлөгдөнө;
- ❖ Эдгээр таамаглалыг оруулснаар ТЗК-ны орох мөнгөн урсгал нь Зээлийн багцын хуваарьт төлбөр, урьдчилан төлөлт, хугацаа хэтрэлт, багцад шинээр нэмсэн зээлийн мөнгөн урсгал зэргээс хамаарна;
- ❖ Гарах мөнгөн урсгал нь дээр дурдсан этгээдүүдэд төлөх тогтмол төлбөр болон ХБҮЦ-ны хүү, үндсэн төлбөрөөс голчлон бүрдэхээр байна.







**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга



**Хүснэгт 9: ТЗК-ийн Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр**

ТАЙЛАНТ УЛИРАЛ									
Үзүүлэлт		I	II	III	IV	V	VI	VII	VIII
Бэлэн мөнгө	1	3,304	2,606	6,017	5,896	9,583	8,401	10,392	8,373
Нийт зээлийн багц	19,394	16,991	14,784	12,163	9,170	5,996	3,779	2,088	-
Эрсдэлийн сан									
<b>Нийт хөрөнгө</b>	<b>19,395</b>	<b>20,295</b>	<b>17,389</b>	<b>18,180</b>	<b>15,066</b>	<b>15,579</b>	<b>12,181</b>	<b>12,480</b>	<b>8,373</b>
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг	15,000	15,000	11,250	11,250	7,500	7,500	3,750	3,750	-
Бусад өглөг	4,394	4,393	4,393	4,393	4,393	4,393	4,393	4,393	3,827
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>19,394</b>	<b>19,393</b>	<b>15,643</b>	<b>15,643</b>	<b>11,893</b>	<b>11,893</b>	<b>8,143</b>	<b>8,143</b>	<b>3,827</b>
Хувьцаат капитал	1	1	1	1	1	1	1	1	1
Хуримтлагдсан ашиг	-	-	901	1,745	2,536	3,172	3,685	4,037	4,336
Татварын дараах ашиг	-	901	844	790	636	513	352	299	208
<b>Нийт өөрийн хөрөнгө</b>	<b>1</b>	<b>902</b>	<b>1,746</b>	<b>2,537</b>	<b>3,173</b>	<b>3,686</b>	<b>4,038</b>	<b>4,337</b>	<b>4,546</b>
<b>Өр төлбөр ба эзний өмч</b>	<b>19,395</b>	<b>20,295</b>	<b>17,389</b>	<b>18,180</b>	<b>15,066</b>	<b>15,579</b>	<b>12,181</b>	<b>12,480</b>	<b>8,373</b>

Эх сурвалж: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тооцоолол

- ❖ Таамаглалаас харахад 2025 онд ТЗК татан буугдах үед **8,373 сая төгрөгийн** бэлэн мөнгө, **565.6 сая төгрөгийн** зээлийн багц Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн тайлан баланс руу шилжихээр тооцоололтой байна.

**Хүснэгт 10: ТЗК-ийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр**

ТАЙЛАНТ УЛИРАЛ									
Үзүүлэлт		I	II	III	IV	V	VI	VII	VIII
Хүүний орлого		1,848	1,791	1,561	1,390	1,063	841	588	480
ХБҮЦ-ийн хүүний төлбөр		(675)	(675)	(506)	(506)	(338)	(338)	(169)	(169)
<b>Цэвэр хүүний орлого</b>	<b>1,173</b>	<b>1,116</b>	<b>1,054</b>	<b>884</b>	<b>726</b>	<b>503</b>	<b>419</b>	<b>311</b>	<b>311</b>
Эрсдэлийн сангийн зардал									
<b>Эрсдэлийн сангийн дараах ашиг</b>	<b>1,173</b>	<b>1,116</b>	<b>1,054</b>	<b>884</b>	<b>726</b>	<b>503</b>	<b>419</b>	<b>311</b>	<b>311</b>
Үйл ажиллагааны зардал		(172)	(178)	(176)	(177)	(156)	(113)	(86)	(80)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>1,001</b>	<b>938</b>	<b>878</b>	<b>707</b>	<b>570</b>	<b>391</b>	<b>332</b>	<b>232</b>	<b>232</b>
Татвар		(100)	(94)	(88)	(71)	(57)	(39)	(33)	(23)
<b>Татварын дараах цэвэр ашиг</b>	<b>901</b>	<b>844</b>	<b>790</b>	<b>636</b>	<b>513</b>	<b>352</b>	<b>299</b>	<b>208</b>	<b>208</b>

Эх сурвалж: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тооцоолол





- ❖ Өмнөх сарын хуваариас өмнө урьдчилж төлөгдсөн дүнгээр дараа сард нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шинээр багц худалдаж авах ба, дараа саруудад нь шинээр худалдаж авч нэмэгдүүлсэн зээлээс мөн хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтүүд орж ирнэ;
- ❖ ТЗК-ийн мөнгөн урсгалын тайланд ХБҮЦ-д анх багцалсан зээлийн багц болон ХБҮЦ гарсны дараа шинээр худалдан авсан зээлийн орох мөнгөн урсгал аль аль нь орж тооцоологдсон.

**Хүснэгт II: ТЗК-ийн мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр**

Үзүүлэлт	ТАЙЛАНТ УЛИРАЛ							
	I	II	III	IV	V	VI	VII	VIII
Хүүгийн орох мөнгөн урсгал	1,798	1,643	1,429	1,144	819	486	280	111
Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал	4,019	4,443	4,563	4,584	4,363	2,969	2,126	1,728
ХБҮЦ-ны үндсэн төлбөр		(3,750)		(3,750)		(3,750)		(3,750)
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр	(675)	(675)	(506)	(506)	(338)	(338)	(169)	(169)
Үйл ажиллагааны зардал	(172)	(178)	(176)	(177)	(156)	(113)	(86)	(80)
Татварын зардалд төлсөн төлбөр	(100)	(94)	(88)	(71)	(57)	(39)	(33)	(23)
<b>Үйл ажиллагааны мөнгөн урсгал</b>	<b>4,870</b>	<b>1,389</b>	<b>5,222</b>	<b>1,224</b>	<b>4,632</b>	<b>(784)</b>	<b>2,118</b>	<b>(2,182)</b>
Хадгаламж, хөрөнгө оруулалтын хүүгийн орлого	50	149	132	246	244	355	308	369
Банкны хадгаламж	50	149	132	246	244	355	308	369
Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт	(1,617)	(2,236)	(1,943)	(1,591)	(1,189)	(753)	(435)	(205)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал</b>	<b>(1,566)</b>	<b>(2,087)</b>	<b>(1,811)</b>	<b>(1,345)</b>	<b>(945)</b>	<b>(398)</b>	<b>(127)</b>	<b>163</b>
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1	3,304	2,606	6,017	5,896	9,583	8,401	10,392
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,304	2,606	6,017	5,896	9,583	8,401	10,392	8,373
(Харилцах+Зээл)/ХБҮЦ	140%	163%	172%	219%	227%	353%	359%	-

Эх сурвалж: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тооцоолол

2023 12 25

БҮГТ



## ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ



### 3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

#### 3.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

##### **Тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах**

Хуулийн этгээд нь СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр ТЗК болж бүртгэгдэнэ. ТЗК нь баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг тусгай зориулалттай хуулийн этгээд тул аливаа ТЗК нэг л удаа ХБҮЦ гаргах эрхтэй байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу Бэрс Финанс ББСБ ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийг үүсгэн байгуулж, холбогдох зөвшөөрлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

##### **Хууль, журмын хүрээнд шаардлага хангаж буй зээлийг багцлан бүрдүүлэх**

Шинээр байгуулагдсан "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн ТУЗ-өөс үйл ажиллагаа, санхүү, хөрөнгийн удирдлага зэрэг үйл ажиллагаа явуулахтай холбоотой дотоод үйл ажиллагааны журмууд батлан гаргасан бөгөөд эдгээр журам, холбогдох тогтоолд үндэслэн "Бэрс Финанс ББСБ" ХХК-аас шаардлага хангаж буй зээлийн багцыг сонгон авч, багцыг шилжүүлэн авна.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 10 сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон 19,393,810,877.39 /арван есөн тэрбум гурван зуун ерэн гурван сая найман зуун арван мянга найман зуун далан долоон төгрөг гучин есөн мөнгө / төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн хөрөнгийг багцалж үнэт цаасны танилцуулгад хавсаргав.

##### **Зээлийн багцын хөндлөнгийн дүгнэлт**

Зээлийн багц нь санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай бөгөөд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагууд зээлийн багцад түүврийн аргаар шалгалт хийж, уг шалгуурт нийцэж буй эсэхэд тус тусын дүгнэлтийг гаргасан болно. Тодорхойлогдсон зээлийн багцад үндэслэн Үнэт цаас гаргагчаас тогтоосон хуулийн шалгуурыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, болон санхүүгийн шалгуур хангасан эсэх зээлийн шинжилгээг "Си Пи Ти Эй Аудит" ХХК боловсруулсан. Ингэхдээ мөн ХБҮЦ-ны тухай хууль, СЗХ, Монголын Хөрөнгийн Биржийн журмуудад тусгасан асуудлаар дүн шинжилгээ хийж, зээлийн багц нь санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан гэж дүгнэжээ.

##### **Шинээр байгуулагдсан ТЗК-д зээлийн багцыг шилжүүлэх**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн эзэмшилд буй зээлийн хөрөнгийг багцалж, 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-ний үндсэн дээр хөрөнгийн багцыг ТЗК-ийн бүртгэлд шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулагчид барьцаалуулсан тус хөрөнгийг хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн эзэмшиж удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ нь үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болно.







### **Эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх**

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, бүртгэлийн зөвшөөрлүүдийг авснаар үнэт цаасыг гаргаж байгаа болно. Үнэт цаас гаргагч нь ҮЦТХТ-өөр дамжуулж Үнэт цаасыг бүртгүүлж хадгалуулах, хүүгийн болон үндсэн төлбөрийн төлбөр тооцоо, эрхийг шилжүүлэх зэрэг үүргийг гүйцэтгүүлнэ.

### **МХБ-ээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох**

МХБ болон СЗХ-оос зөвшөөрөл авсны үндсэн дээр Андеррайтер нь эрх бүхий байгууллагуудаас гаргасан үнэт цаасыг танилцуулах хууль, дүрэм журмын хүрээнд тогтоосон хугацаанд анхдагч зах зээлд олон нийтэд сурталчилж, санал болгон арилжаалж, захиалгыг хүлээн авна.

Худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид МХБ-ээр дамжуулж Үнэт цаас олон нийтэд санал болгох анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд өөрийн ҮЦТХТ-д бүртгэлтэй дансанд захиалгын мөнгийг шилжүүлж, арилжаанд оролцоно. Арилжаа амжилттай явагдсаны дараа Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдын дансанд байршуулна. Ингэснээр ХБҮЦ-ны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд авах эрх үүснэ. Үнэт цаас гарган татан төвлөрүүлсэн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

### **Хөрөнгө Итгэмжлэн удирдах**

"Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-с баталсан Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, бусад хууль, журам болон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу "Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК-аар дамжуулж хөрөнгийг итгэмжлэн удирдуулна. Ингэхдээ ХБҮЦ-ны багцтай холбоотой хөрөнгийг бүртгэх, тайлагнах зэрэг үйлчилгээг Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, СЗХ, МХБ-н баталсан журамд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

### **Тусгай зориулалтын компанийг татан буулгах**

Тусгай зориулалтын компанийг дараах нөхцөлүүдэд татан буулгана. Үүнд:

1. Үнэт цаасны танилцуулга, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр, хууль тогтоомж болон холбогдох журамд заасан баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэсэн,
2. Баталгаат үнэт цаасны Хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдсан,
3. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан бол Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу ТЗК-г татан буулгана.

Тусгай зориулалтын компанийг өөрчлөн байгуулах, дахин үүсгэн байгуулах үйл ажиллагаа хийгдэхгүй.

### **Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилах**





**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилахад дараах дарааллыг баримтална:


1. Татан буулгах ажиллагааны зардал;
2. Хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр;
3. Тусгай зориулалтын компаниас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх этгээдийн шаардлага;
4. Авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага;
5. Үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно.

“Бэрс-3 ХБҮЦ” үнэт цаасны үнэт цаасжуулах процесст оролцогчид нь дараах болно:

**Хүснэгт 12: ХБҮЦ үнэт цаасжуулах процесст оролцогч талууд**

	Компани	Үүрэг
	“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК	Үнэт цаас гаргагч
	“Бэрс финанс ББСБ” ХХК	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Үйлчилгээ үзүүлэгч Үүргийн гүйцэтгэл хангуулагч
	“Өмгөөллийн Эм Ди Эс энд Ханлекс” ХХН	Зээлийн багцад хууль зүйн дүгнэлт гаргагч Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч
	Си Пи Ти Эй Аудит ХХК	Зээлийн багцад зээлийн шинжилгээ гаргагч
	“Юү Эй Эф Ассет Менжмент” ХХК	Хөрөнгө итгэмжлэн удирдагч
	Голомт капитал ҮЦК ХХК	Андеррайтер





МОНГОЛЫН ХАМГААГАХ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2023 - 25  
БҮРТГЭЛЭГ

MDS KhanLex

AUDIT LLC

БЭРС ФИНАНС  
BANK OF SECURITIES AND CAPITAL MARKET

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
MONGOLIAN  
STOCK EXCHANGE  
ҮЦТХТ

СЗХ  
2023.12.22  
Colorful University

БЭРС  
ЭЙ БИ ЭС  
ЛОЯЛТИ  
ТЭК ХХК  
УЛААНБААТАР НОТ  
УЛСЫН ГЭРЭЭНИЙ  
УДИРДАГЧ  
2023.12.22



### 3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГЭРЭЭНҮҮД

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/26а/07 тоот ТУЗ-ийн тогтоолын дагуу үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг сонгосон байна.


Тус тогтоолын дагуу Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийг, Зээлийн шинжилгээ гаргагч байгууллагаар “Си Пи Ти Эй Аудит” ХХК-ийг, Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч байгууллагаар “Юү Эй Эф Ассет Менжмент” ХХК-ийг, Андеррайтераар “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийг тус тус сонгосон байна. Түүнчлэн ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотой зарим гэрээний оролцогч тал нь сонирхлын зөрчилтэй этгээд буюу үүсгэн байгуулагч “Бэрс финанс ББСБ” ХХК байгаа тул Үнэт цаас гаргагчийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/26а/08 тоот ТУЗ-ийн тогтоолоор сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг олгосон байна.

#### Хүснэгт 13: Үнэт цаас гаргагчийн оролцогч талуудтай хийсэн гэрээ

Гэрээ/Огноо	Оролцогч талууд	Гэрээний агуулга
1 23/753 тоот Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ 11/16/2023	-Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК ХХК  -Бэрс финанс ББСБ ХХК	Гэрээгээр зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, түүний эсрэг гэрээнд заасан үнийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солих, нэмэх, буцаах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.
2 23/754 тоот Фидуцийн барьцааны гэрээ 11/16/2023	-Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК ХХК  -Бэрс финанс ББСБ ХХК	Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний дагуу ББСБ-аас ТЗК-д худалдсан хөрөнгийн багцад ногдох Фидуцийн барьцааны гэрээний дагуу ББСБ-ийн өмчлөлд шилжсэн автомашинуудыг энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үүргийн гүйцэтгэлд барьцаалуулахтай холбоотой харилцааг уг гэрээгээр зохицуулсан байна.
3 23/756 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ 11/16/2023	-Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК ХХК  -“Юү Эй Эф Ассет Менжмент” ХХК	Гэрээгээр Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд баримтлах бодлого, хөрөнгийн багцыг хянах, төлбөр төлөх, багцад өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих зэрэг харилцааг зохицуулсан байна. Гэрээний дэлгэрэнгүйг 6. Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэсэгт оруулав.







	23/755	тоот	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ	11/16/2023	-Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК ХХК -Бэрс финанс ББСБ ХХК -"Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн багцад багцалсан зээлийн төлбөрийг Зээлийн эргэн төлөлтийн дансанд төвлөрүүлэх, уг төлбөрийг ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд шилжүүлэх, хянах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.  Гэрээний дэлгэрэнгүйг 5. Үйлчилгээ үзүүлэгчийн тухай хэсэгт дэлгэрэнгүй оруулав.
5	23/757	тоот	Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ	11/16/2023	-Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК ХХК -Бэрс финанс ББСБ ХХК -"Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасан зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цугларах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор Зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд гэрээ болон журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
6	23/758	тоот	Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ	11/16/2023	-Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК ХХК -Бэрс финанс ББСБ ХХК	Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэл хөтлөх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ-ийн хяналт доор хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар төлөх, компанийн цахим хуудас хөтлөх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулсан байна. ТЗК-ийн байгууллагын тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, тусгай зөвшөөрөл, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан зэрэг баримт бичгийг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч өөрийн ажлын байранд хадгалах бөгөөд аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээж, баталгаа гаргасан байна.
7	23/81	тоот	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ	2023/10/09	-Бэрс Финанс ББСБ ХХК -Голомт Капитал ҮЦК ХХК - Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК ХХК	Компанид Хөрөнгийн зах зээлээс 15.0 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгож, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлага магадлан шинжилгээ, тооцоо, судалгааг хийж, бэлтгэл ажлыг ханган үнэт цаасыг нийтэд санал болгох, мэргэжлийн
	23/81-1	тоот	Андеррайтерийн үйлчилгээний гэрээнд нэмэлт			





2023.12.27

МОНГОЛЫН УИХ  
MONGOLIAN PARLIAMENT  
Үнэт цаасны танилцуулга  
2023 25

өөрчлөлт оруулах  
тухай гэрээ

үйлчилгээ үзүүлэх үйлчилгээг  
зохицуулсан байна.

2023/11/16

8	Зээлийн шинжилгээ гаргах гэрээ	-Бэрс ББСБ ХХК	Финанс	"Бэрс финанс ББСБ" ХХК нь сонгогдсон зээлийн данснууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар Си Пи Ти Эй Аудит ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр "Зээлийн санхүүгийн шинжилгээ хийх гэрээ" мастер гэрээ, 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр "Хавсралт I гэрээ" байгуулсан байна. Гэрээгээр гэрээт ажлын цар хүрээ буюу сонгогдсон зээлийн хувийн хэргийг харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу хянаж, ажил үйлчилгээний гүйцэтгэл болон илрүүлсэн асуудлуудыг нэгтгэж тайлагнах асуудлыг зохицуулжээ.
	2023/10/20	-Си Пи Ти Эй Аудит ХХК		
9	Хууль зүйн дүгнэлт гаргах гэрээ	-Бэрс ББСБ ХХК	Финанс	Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах, Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгох хүрээнд төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, байгуулсан гэрээ, гэрээний төслүүд нь хүчин төгөлдөр, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргаж, үнэт цаасны холбогдох зөвшөөрөл авах асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, багцын хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлж, хөрөнгийн багцад шинжилгээ хийж, тайлан гаргуулахаар тохиролцож гэрээ байгуулсан байна.
	2023/10/09	-Эм Ди Эс Ханлекс ХХК		
10	ЛА-23/69 Программ түрээсээр гэрээ	тоот хангамж ашиглах	-Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК ХХК -Грэйпсители Монгол ХХК	Грэйпсители Монгол ХХК нь Поларис суурь системтэй хоршин ажиллах системийг үнэт цаас гаргагчид түрээсээр ашиглуулах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нууцлал, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг гэрээгээр тохирсон байна.
	2023/11/16			





### 3.3. ХӨРӨНГИЙН БАГЦ

#### 3.3.1. ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИХ САНХҮҮГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

“БЭРС ЭЙ БИ ЭС ЛОЯАЛТИ ТЗК” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/26a/06 тоот ТУЗ-ийн тогтоолоор Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ийн ерөнхий нөхцөл болон ХБҮЦ-д багцлах зээлийн хөрөнгөд дараах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг тавихаар заажээ.



##### Шалгуур 1:

Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;



##### Шалгуур 2:

Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;



##### Шалгуур 3:

Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;



##### Шалгуур 4:

Фидуцийн барьцааны гэрээний зүйл нь тээврийн хэрэгслийн даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх;



##### Шалгуур 5:

Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;



##### Шалгуур 6:

Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх;



##### Шалгуур 7:

Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (**ӨОХ**) нь татварын өмнөх орлогын **60%-с** илүүгүй байх;

ӨОХ = зээлийн сарын төлбөр / (Өрхийн сарын орлого (татвараас өмнөх))



##### Шалгуур 8:

Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (**ЗҮХ**) **80%-с** хэтрэхгүй байх.

ЗҮХ = (Тасалбар болгох өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн үлдэгдэл) / (Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ)



##### Шалгуур 9:

Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх;



##### Шалгуур 10:

Үндсэн зээлдэгчийн орлого дангаар ӨОХ хангахгүй байгаа тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэгчийн орлогыг судална. /Орлого нотлох баримт авна/

Орлого нотлох баримт: Сүүлийн 6 сарын дансны хуулга эсвэл НДШ лавлагаа;



2023.12.25

**3.3.2. ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИХ ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

“БЭРС ЭЙ БИ ЭС ЛОЯАЛТИ ТЗК” ХХК-ийн ТУЗ-аас “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний нөхцөлд заасны дагуу Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-д багцлах зээлийн хөрөнгөд дараах хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг баримтална.

**Шалгуур 1:**



Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;

**Шалгуур 2:**



Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг фидуци/барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;

**Шалгуур 3:**



Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан Фидуцийн барьцааны гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;

**Шалгуур 4:**



Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, Фидуцийн барьцааны гэрээ зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;

**Шалгуур 5:**



Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;


**Шалгуур 6:**



Фидуцийн барьцааны гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.







**3.3.3. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ГОЛЛОХ МЭДЭЭЛЭЛ**

Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс санал болгосон автомашины фидуци бүхий 2023 оны 10-р сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон нийт 1,539 зээлийн гэрээнээс бүрдсэн 19,393,810,877.39 (арван есөн тэрбум гурван зуун ерэн гурван сая найман зуун арван мянга найман зуун далан долоо төгрөг гучин есөн мөнгө ) төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн багцыг бүрдүүлсэн. Хөрөнгийн багцын жагсаалтыг хавсралтаас харна уу.

**Хүснэгт 14: Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт**


<b>Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт</b>	
	<i>Дүн /төгрөгөөр/</i>
Нийт автомашины зээлийн үлдэгдэл	19,393,810,877.4
Зээлийн хөрөнгийн барьцааны дүн	34,764,920,000.0
Зээлийн гэрээний тоо	1,539
Зээлийн дундаж үлдэгдэл	12,601,566.5
Барьцааны дундаж дүн	22,589,291.8
Жигнэсэн дундаж хүү /сар/	3.3%
Жигнэсэн дундаж хугацаа /сар/	44.9
Жигнэсэн дундаж LTV%	57.1%
Сарын дундаж төлбөрийн дүн	749,414.1
<b>Багцын зээлийн чанар</b>	<b>100% хэвийн зээл</b>

Хөрөнгийн багц бүрдүүлж буй зээл нь автомашины фидуци бүхий зээл бөгөөд зээлдүүлэгч нь автомашины өмчлөлийг шилжүүлэн авч, зээлдэгч зээлийн төлбөрийг төлөхгүй нөхцөлд тус автомашиныг худалдан борлуулах замаар зээлийн үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөлтэй зээл юм. Автомашины зээл нь нийт Хөрөнгийн багцын 100 хувийг бүрдүүлж байна.

Хөрөнгийн багцад хөрөнгийн 20 болон түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа үүрэг гүйцэтгэгч байхгүй болно.

**Зээлийн дүн:** Автомашины фидуци бүхий зээлийн багц нь анх ойролцоогоор 22.3 тэрбум төгрөгийн зээл олгогдсон ба хуваарийн дагуу эргэн төлөлт хийгдсээр 19.39 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн багц болсон байна. Тиймээс зээл тус бүрийн үлдэгдлийг үнийн дүнгээр нь задалж харвал 1,539 зээлээс нь дийлэнх нь 10 сая төгрөг хүртэлх болон 10-20 сая төгрөг хүртэлх үлдэгдэлтэй зээл байгаа бол 40-70 сая хүртэлх дүнтэй зээл 9 ширхэг байна. Хамгийн өндөр дүнтэй нь 174.4 сая төгрөгийн үлдэгдэл бүхий нэг зээл байна.

**График 2: Фидуци бүхий зээлийн багцын задаргаа /үлдэгдэл дүнгээр/**



2023.12.27


**Bers ABS**  
Loyalty

 МОНГОЛЫН ХААМ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

 2023.12.27  
Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-03

**Зээлийн хугацаа:** Хөрөнгийн багцад багтах зээлүүдийн анх олгосон дундаж хугацаа нь 44.9 сар байна. Түүнчлэн мөнгөн дүнгээр тооцвол зээлийн багцын дийлэнх нь 36 сараас дээш хугацаатай зээлүүд юм. Харин зээлийн багцад шинээр зээл худалдаж авах, солих, зээл урьдчилан төлөгдөх зэргээр багцын дундаж хугацаа ХБҮЦ-ны явцад өөрчлөгдөж болох ба эдгээр зохицуулга нь ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлттэй мөнгөн урсгалыг нийцүүлэх боломжийг бүрдүүлнэ.

#### Хүснэгт 15: Фидуци бүхий зээлийн багцын хугацааны задаргаа

Анх олгосон хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
0-6 сар	1	6.5	0.0%
6-12 сар	30	206.26	1.1%
12-24 сар	8	45.29	0.2%
24-36 сар	125	1,110.96	5.7%
36 сараас дээш	1375	18,024.79	92.9%
<b>Нийт</b>	<b>1,539</b>	<b>19,393.81</b>	<b>100%</b>


Автомашин зээлийн багцыг хугацаагаар харвал үнэт цаас гаргагч нь багцад хэт богино хугацаат зээл оруулахгүй байх зарчмыг баримталсан байна. Учир нь хэт богино хугацаат зээлүүд нь ХБҮЦ-ийн зөвшөөрөл авах үе шат болон, ХБҮЦ-ийн эхэн үед хуваариас өмнө төлөгдөх магадлал өндөртэй байдаг.

**Зээлийн хүү, эргэн төлөлт:** Зээлийн багцын жигнэсэн дундаж хүү сарын 3.3% байна. Түүнчлэн зээлийн багцаас эргэн төлөгдөх зээлийн хүү болон үндсэн төлбөрүүд нийтдээ ХБҮЦ-ийн эхэн үед ойролцоогоор сард 1,153.3 сая төгрөг байх ба зээлүүд төлөгдөж хаагдах тусам эргэн төлөлтөөс орж ирэх дүн буурна. Нэг зээлдэгчийн сард төлөх хуваарьт төлбөр нь 749,414.1 төгрөг болж байна. Харин зээлийн хуваарьт төлбөрийн эргэн төлөх огноо нь сарын харилцан адилгүй өдрүүдэд тохиож байна.

**Зээлдэгч:** Хөрөнгийн багцад багтсан 1,539 зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн олгосон зээлүүд учраас Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хөдөө орон нутаг болон Улаанбаатар хот дахь харилцан адилгүй салбарууд дээр олгогдсон зээл байна.

Нийт 1,539 зээл байгаагаас нэг зээлдэгчийн авсан 2 зээл байгаагаас бусдаар зээлдэгчийн аливаа давхцал байхгүй, өөрөөр хэлбэл нэг зээлдэгчээс хамаарах хамаарал бага байна. Түүнчлэн хамгийн өндөр дүнтэй зээл буюу 174.4 сая төгрөгийн нэг зээл байгаа нь багцын хувьд тооцоход эргэн төлөлт, мөнгөн урсгалд материаллаг нөлөө байхгүй, багцын 0.89% тай тэнцэж байна. Зээлдэгчийн хувьд өр орлогын харьцаа (ӨОХ) нь бага байх нь өрийн дарамт бага байх, зээлийн эргэн төлөлтөд саатал гарахгүй байх үндсэн шалгуур болдог. Өр орлогын харьцааг тооцохдоо зээлдэгчийн өрхийн сарын орлогод эзлэх сарын эргэн төлөлтийг хувь хэмжээгээр тооцох бөгөөд нийт зээлийн багцын хувьд ӨОХ нь дунджаар **22.2%** байна.

**Барьцаа хөрөнгө:** Фидуци бүхий зээлийн багц нь бүх барьцаа хөрөнгө нь тухайн зээлээр авч буй автомашин өөрөө байдаг онцлогтой. Эдгээр автомашины үйлдвэрлэсэн дундаж хугацаа 2010 он, импортоор оруулж ирсэн огноо нь 2020 он ажээ. Фидуци бүхий барьцааны дундаж үнэлгээ 22.5 сая төгрөг. Харин хамгийн бага үнэлгээ нь 5.0 сая төгрөг, хамгийн өндөр үнэлгээтэй автомашин нь 525.0 сая төгрөгийн машин байна. Фидуци бүхий зээлээр баталгаажсан энэхүү хөрөнгийн багцын ЗҮХ нь дунджаар 57% байна.





**3.4. ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙН БАГЦЫН ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**



Бэрс-3 ХБҮЦ-ны хөрөнгийн багц дахь зээлүүд нь дээр дурдсан хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН дүн шинжилгээ хийсэн бөгөөд зээлийн хөрөнгийн нэгдсэн багцаас 93% итгэлцлийн түвшин, 7%-ийн хүлээгдэж буй алдааны дээд хязгаартай байхаар тооцож 40 зээлийн дэд дансыг санамсаргүй түүврийн аргаар сонгож дүн шинжилгээ хийжээ.

Тэгэхдээ санхүүгийн хөндлөнгийн шинжээчийн сонгосон данстай давхардуулахгүй байх, зээл олгосон дүн 20.0 сая төгрөгөөс дээш байх, зээлийн үлдэгдэл 18.9 сая төгрөгөөс дээш байх шалгуурыг мөн тавьсан байна. Энэхүү түүвэрт багтсан 40 данс нь ТЗК-ийн баталсан хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

Дүн шинжилгээ хийж, тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг, эсхүл гол нөхцөл тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийг дахин үнэлэх шаардлагатай, хүчин төгөлдөр бусад тооцогдож болзошгүй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн данс илрээгүй байна.

Хуулийн фирм нь зээлийн багцын шинжилгээний явцад анхаарах, ББСБ-д ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалтыг тайлангийн хавсралтаар гаргаж, тус илрүүлсэн зөрүүтэй зохицуулалтыг хүлээн зөвшөөрч, шинжилгээ хийх явцад гарсан алдаа, зөрчлийг тухай бүр засуулсан байна.

**3.5. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН**




Зээлийн шинжилгээ гаргагч буюу “Си Пи Ти Эй Аудит” ХХК нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу хөрөнгийн багцад сонгогдсон зээлийн материалуудыг шалгаж, дээрх санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд хийсэн шалгалтын үр дүнг тайлагнасан байна.

Энэхүү гэрээт ажил нь АОУС болон Нягтлах үйлчилгээний олон улсын стандартын дагуу аудит эсвэл хянах ажиллагаанд тус тус хамаарахгүй ба зээлүүдийн жагсаалт болон тэдгээрийн хувийн хэргийн иж бүрдэл, үнэн зөв байдлыг мэдээлэл өгөгч тал хариуцна.

Зээлийн багцын эх олонлог болох 1,539 зээлээс итгэлцлийн түвшин 95%, байж болох алдаа 10%, хүлээгдэж буй алдаа 5% гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан, урт хугацаат зээлүүдээс нийт 120 зээлийг сонгон шалгасан байна. Түүвэрлэлт хийхдээ ЗҮХ болон ӨОХ өндөр зээлийн дансыг аль болох ихээр хамруулах, салбар бүрээс багадаа 2 зээл хамрагдсан байх, зээлийн үлдэгдлийн хэмжээг харгалзахгүй байх, Улаанбаатар болон орон нутгаас сонгосон зээлийн тоо нь нийт багцын харьцаатай ойролцоо байх гэдэг зарчмуудыг баримталсан байна.

Түүвэр 120 зээлд хийсэн шалгалтын дүнд түүвэрт багтсан бүх зээл Шалгуур 1-6, 9 шалгууруудыг хангасан бол 11 зээлдэгчийн өр орлогын харьцаа 60%-аас хэтэрсэн, 3 зээлдэгчийн зээл үнэлгээний харьцаа 80% хэтэрсэн байна.

Үүнээс харахад түүврийн ойролцоогоор 9% нь ӨОХ-ны, 2.5% нь ЗҮХ-ны шалгуур хэтэрсэн байна.





**ДӨРӨВ. АНХНЫ ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ**

---





#### 4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

##### 4.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан гэрээний тухай

###### Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ

**Оролцогч талууд:** Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК ХХК – Бэрс финанс ББСБ ХХК

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 11 дугаар сарын 16-ны өдөр анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу “Бэрс финанс ББСБ” ХХК-тай 23/753 тоот “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ” байгуулсан байна. Гэрээгээр зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, түүний эсрэг гэрээнд заасан үнийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солих, нэмэх, буцаах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад хөрөнгө оруулалтын хэмжээ талуудын хооронд тохирсон хэлцэл биелэх дүнд хүрсэн тохиолдолд төлбөрийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн төлбөр хүлээн авах дансанд шилжүүлнэ.

Хөрөнгө оруулалтаас босгосон дүн нь хэлцэл биелэх дүнд хүрээгүй тохиолдолд хэлцлийг амжилтгүй болсон хэмээн үзэж, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багц дахь зээлийн дансны бүртгэлийг тусад нь хөтөлж, холбогдох баримт бичгийг өөрийн оффис дээр хадгална.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагч руу худалдаж буй зээлийн багцын дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтад жагсаалтаар оруулж баталсан.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцад шалгуур хангасан хөрөнгийг оруулах ба хөрөнгө, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, холбоотой баримт бичгийг үнэн зөв гаргаж өгнө. Хөрөнгө Үнэт цаас гаргагчид бүрэн шилжихэд ямар нэг хязгаарлалтгүй байна.



ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, бусад нэмэлт үүрэг байхгүй, хөрөнгийн багцад байгаа зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй болохыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч баталгаа гаргажээ.

###### Фидуцийн барьцааны гэрээ

**Оролцогч талууд:** Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК ХХК – Бэрс финанс ББСБ ХХК

Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ-ний дагуу ББСБ-аас ТЗК-д худалдсан хөрөнгийн багцад ногдох Фидуцийн барьцааны гэрээний дагуу ББСБ-ийн өмчлөлд шилжсэн автомашинуудыг энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үүргийн гүйцэтгэлд барьцаалуулахтай холбоотой харилцааг уг гэрээгээр зохицуулна.


Гэрээний дагуу “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК нь барьцаалагч байх ба “Бэрс финанс” ББСБ нь барьцаалуулагч байна. 23/754 тоот Фидуцийн гэрээг 2023 оны 11 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан бөгөөд ТЗК-ийн ХБҮЦ-аар хүлээсэн үүрэг бүрэн биелэгдэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байж, уг үүрэг бүрэн биелснээр дуусгавар болно. Барьцаалуулагч нь Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний дагуу хүлээсэн үүргээ хууль, гэрээнд заасан нөхцөлийн дагуу биелүүлээгүй тохиолдолд барьцаалуулагчийн барьцааны зүйлийн хувьд эдлэх аливаа эрхийг (шаардах эрх, одоо болон ирээдүйд үүсэх эд хөрөнгийн эрх, орлого, үр шим хүртэх эрх гэх мэт) “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК”



2023.12



**Bers ABS**  
loyalty



...ХХК-д шилжүүлж, бусад үүрэг гүйцэтгүүлэгчээс тэргүүн ээлжид барьцааны зүйлээс шаардлага хангуулах эрх үүснэ.

Фидуцийн барьцааны гэрээний зүйл болох автомашин болон түүнтэй холбоотой эрхийн мэдээллийг гэрээний хавсралтад жагсаалтаар оруулж өгсөн байна.

**Барьцаалуулагч барьцааны зүйлтэй холбоотойгоор дараах баталгааг гаргасан:**

- ❖ Барьцаалуулагч нь Барьцааны зүйлийн өмчлөгч мөн болно.
- ❖ Барьцаалуулагч нь Фидуцийн барьцааны гэрээний дагуу барьцааны зүйлийг ТЗК-д барьцаалах бүрэн эрх, эрх мэдэл, эрх зүйн чадамж, хууль ёсны эрхтэй ба барьцааны зүйлийг барьцаалуулахад шаардлагатай бүхий л зөвшөөрөл, баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн;
- ❖ Гэрээ дуусах хүртэл барьцааны зүйлийг аливаа хохирол, өр төлбөр, зардал, анз, маргаан, хэрэг, шүүхийн ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл зэргээс ангид байлгана;
- ❖ Барьцаалуулагчийн хүлээсэн үүрэг нь хууль ёсны, хүчин төгөлдөр бөгөөд Барьцаалуулагчийн хүлээсэн үүрэг, хариуцлага нь түүний аливаа дотоод баримт бичиг, дүрэм журам, Барьцаалуулагчийн хувьд заавал биелүүлэх аливаа шүүх, арбитрын шийдвэр, гэрээ хэлцэлтэй зөрчилдөхгүй.
- ❖ Барьцааны зүйлийг бүхэлд нь болон хэсэгчлэн хураах, нийгэмчлэх, битүүмжлэх, аливаа гуравдагч этгээдээс хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэх ба бусад байдлаар халдаж болзошгүй хүчин зүйлсээс ангид байлгах, хэрэв үүссэн тохиолдолд нэн даруй мэдэгдэнэ;
- ❖ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж, хуулийг чандлан баримтална;
- ❖ Барьцааны зүйлд аливаа гуравдагч этгээдийн барьцааны эрх, шаардах эрх үүсээгүй, барьцааны зүйл нь эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй.





**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга адар

2023.12.22

#### 4.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үүсгэн байгуулагчийн үйл ажиллагааны тухай


Үүсгэн байгуулагч Бэрс Финанс ББСБ ХХК нь 2017 оны 5 дугаар сарын 18-нд үүсгэн байгуулагдаж, ББСБ үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж эхэлжээ. Тус компани нь өдгөө 5 тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар болон хөдөө орон нутагт 21 салбар, 80 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулдаг хэрэглэгчдэд танигдсан банк бус санхүүгийн байгууллага болоод байна.

#### Хүснэгт 16. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн талаарх мэдээлэл

<b>Нэр</b>	<b>БЭРС ФИНАНС ББСБ ХХК</b>
<b>Лого</b>	 <b>БЭРС ФИНАНС</b> <small>САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА</small>
<b>Хаяг</b>	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот
<b>Улсын бүртгэлийн дугаар</b>	9015005096
<b>Регистрийн дугаар</b>	6186858
<b>Гүйцэтгэх захирал:</b>	С.Отгонбат
<b>Хувьцаа эзэмшигч</b>	Бэрс Капитал ХХК \100%\
<b>Имэйл</b>	info@bersfinance.mn
<b>Утас</b>	(976) 7712-2020
<b>Цахим хуудас</b>	www.bersfinance.mn

Бэрс Финанс ББСБ ХХК-ийн 100% хувьцаа буюу нэг бүр нь 6,090,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1000 ширхэг хувьцааг Бэрс Капитал ХХК эзэмшдэг бөгөөд **Бэрс Капитал ХХК нь** 2015 оны 1-р сарын 19-нд байгуулагдсан, 100% иргэн Самдан овогтой Отгонбатын хувь эзэмшилтэй компани юм. Хувьцаа эзэмшигч Отгонбат нь мөн Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн 94.4 хувийг эзэмшдэг, өөрөөр хэлбэл бус санхүүгийн салбарт олон жилийн туршлагатай юм.

#### Хүснэгт 17: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн толгой компанийн тухай

<b>Нэр</b>	<b>БЭРС КАПИТАЛ ХХК</b>
<b>Лого</b>	 <b>БЭРС Капитал</b> <small>Хөгжлийн нүүдэл</small>
<b>Хаяг</b>	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол, 3-р хороо, 2 хороолол, Замчдын гудамж, 18-2 тоот
<b>Улсын бүртгэлийн дугаар</b>	9011526089
<b>Регистрийн дугаар</b>	РД: 5922178
<b>Хувьцаа эзэмшигч</b>	С.Отгонбат \100%\
<b>Үйл ажиллагаа</b>	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэх
<b>Холбоо барих</b>	<a href="mailto:otgonbat@bichilglobus.mn">otgonbat@bichilglobus.mn</a> 99119632



2023.12


**Bers ABS**  
Loyalty

 MONGOLIAN STOCK EXCHANGE  
 УНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

2023.12.25

Үүсгэн байгуулагч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл-ажиллагааг эрхэлж байна:

### Хүснэгт 18. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны чиглэл

№	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн огноо	Үйл ажиллагаа явуулдаг эсэх
1	Зээл	7/5/2017	Тийм
2	Факторинг	11/14/2018	Тийм
3	Итгэлцэл	6/10/2020	Тийм
4	Төлбөрийн баталгаа гаргах	2/23/2022	Тийм
5	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	06/30/2023	Тийм

“Бэрс Финанс ББСБ” ХХК нь 19 аймаг, дүүрэгт 21 салбартайгаар иргэдийн бичил зээл олголтын үйл ажиллагааг үзүүлж байна.

### Зураг 1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн салбаруудын байршил



Эх сурвалж: “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн мэдээлэл

#### 4.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн удирдлагын бүтцийн тухай

**ТУЗ:** Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Компанийн дүрмийн 7.1 дэх заалтад тусгаснаар компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хурлын чөлөөт цагт Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ба компанийн хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Харин энгийн болон хараат бус гишүүний тооны харьцаа, гишүүдийн бүрэн эрхийн хугацааг компанийн дүрмээр нарийвчлан тодорхойлоогүй байна.

ТУЗ-ийн даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил ба, 1 удаа улиран сонгогдох эрхтэй.







**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

2023.12.22

**Бэрс Финанс БСБ ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ядамсүрэн овогтой Оюумаа**

**Боловсрол:**

2003-2008 он Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль – Англи хэлний орчуулагч

**Туршлага:**

2008 – 2009 он Хаан банк – Орлогч захирлын туслах

2009 – 2010 он Хадгаламж банк – Гадаад харилцааны менежер

2010 онд Капитал банк – Гадаад төлбөр тооцооны мэргэжилтэн

2018 оноос одоог хүртэл Эко Кар Центр ХХК – Худалдааны зөвлөх

**ТУЗ-ийн гишүүн Самдан овогтой Дамдинбазар**

**Боловсрол:**

2012-2016 он - Сити дээд сургууль – Үйлдвэрлэлийн менежментийн бакалавр

**Туршлага:**

2003 – 2007 онд Улаанбаатар төмөр зам ХНН – Ахлах менежер

2010 – 2012 онд Бичил Глобус ХХК – Эрсдэл хариуцсан захирал

2012 – 2017 онд Бичил Глобус ХХК – Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

2017 оноос одоог хүртэл - Хувиараа бизнес эрхлэгч

**ТУЗ-ийн гишүүн Жадамба овогтой Мөнхсоёмбо**

**Боловсрол:**

1999-2003 он Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль – Бизнесийн удирдлагын бакалавр

**Туршлага:**

2003 – 2005 онд Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль – Бизнесийн зөвлөх төвийн зөвлөх

2009 – 2011 онд Бичил Глобус ХХК – Салбарын эрхлэгч

2011 – 2016 онд Хос Шивээт ХХК – Гүйцэтгэх захирал

2016 оноос одоог хүртэл – Хувиараа бизнес эрхлэгч

**ТУЗ-ийн хараат бус гишүүн Батсуурь овогтой Батсолонго**

**Боловсрол:**

2002-2007 он: ШУТИС Холбоо мэдээллийн технологийн сургууль – Мэдээллийн сүлжээний инженерийн бакалавр

2007-2009 он: ШУТИС Холбоо мэдээллийн технологийн сургууль – Мэдээллийн сүлжээний инженерийн магистр

2016 оноос одоог хүртэл: МУБИС – Боловсролын удирдлагын Докторант

**Туршлага:**

2006-2008 он: Улуснэт ХХК – Инженер

2008-2009 он: Засгийн Газрын хэрэг эрхлэх газар – Шинжээч

2009-2010 он: ГХБАБГазрын “Үндэсний газрын мэдээллийн систем”-ийн төсөл – Инженер

2011-2012 он: ЗГХА Төмөр замын газар – Бүртгэлийн техникч

2012-2013 он: МТШХХГазар – Мэргэжилтэн

2013 оноос одоог хүртэл: МУБИС – Менежер, албаны дарга





**ТУЗ-ийн хараат бус гишүүн Дашдаваа овогтой Гантулга**

**Боловсрол:**

2008-2012 он: Дархан Дээд Сургууль – Аялал жуулчлал, гадаад хэлний удирдлагын ухааны бакалавр

**Туршлага:**

Гоэн девелопмент ХХК – Гүйцэтгэх захирал

**Бүтэц:** Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь нийт 6 газар, 80 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг нь банк санхүүгийн салбарт 5-23 жил ажилласан туршлагатай, мэргэжлийн баг хамт олноос бүрддэг.

**Схем 2: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт**





**Гүйцэтгэх захирал С.Отгонбат**

**Боловсрол:**

2006-2010 он: Алтай коллеж – Компьютерын техникийн инженер, бакалавр  
2011-2013 он: Монгол Улсын Их Сургууль – Олон Улсын эдийн засгийн харилцаа, магистр

**Туршлага:**

2006-2007 он: Оргил Хотхон ХХК – Гүйцэтгэх захирал  
2008-2009 он: Номин Холдинг ХХК – Ахлах менежер  
2013 оноос одоог хүртэл: Бичил Глобус Финанс ББСБ ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал  
2015 оноос одоог хүртэл: Бэрс Капитал ХХК-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал  
2017 оноос одоог хүртэл: Бичил Глобус ХХК, Бэрс Финанс ББСБ ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал

**Дэд захирал Б.Баярчимэг**

**Боловсрол:**

1999-2003 он СЭЗДС – Банк, санхүүгийн бакалавр  
2019-2020 он ХААИС – Бизнесийн удирдлагын магистр

**Туршлага:**

2003 – 2017 онд Төрийн банк – Хяналт шалгалтын газрын захирал  
2018-2019 онд Голомт Банк – Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал  
2019 оноос Бэрс Финанс ББСБ – Дэд захирал

**Хөрөнгө зохицуулалт хариуцсан захирал Я.Адьяахүү**

**Боловсрол:**

2006-2010 он: Алтай коллеж – Компьютерын техникийн инженер, бакалавр  
2011-2013 он: Монгол Улсын Их Сургууль – Олон Улсын эдийн засгийн харилцаа, магистр

**Туршлага:**

1992-1997 он: Зах зээлийн судлалын хүрээлэн – Судлаач  
1998-2009 он: ХХБ -Эдийн засагч, эрсдэлийн шинжээч, ДХА, Газрын ахлах  
2009-2015 он: Хас банк - Хэлтсийн захирал, Газрын захирал  
2015-2017 он: Глашиер ассет ХОМК -Гүйцэтгэх захирал  
2018-2020 он: Нэткапитал ББСБ - Эрсдэлийн захирал, Дэд захирал  
2020-2023.09 сар: Бэрс финанс ББСБ - Санхүү бүртгэлийн газрын захирал  
2023.09-одоог хүртэл: Бэрс финанс ББСБ -Хөрөнгө оруулалтын газрын захирал





**Дотоод хяналтын газрын захирал Г.Юмсүрэн**

**Боловсрол:**

2005-2010 он: ХҮДС – Бизнесийн удирдлагын бакалавр

2018-2020 он: СЭЗИС – Бизнесийн удирдлагын магистр

**Туршлага:**

2011 онд Бичил Глобус ХХК – Менежер

2011-2017 онд Бичил Глобус Групп ХХК – Ахлах менежер, Салбарын захирал, Хяналт эрсдэл хариуцсан захирал

2017-2019 онд Бичил Глобус ХХК – Зээлийн хэлтсийн захирал

2019 оноос Бэрс Финанс ББСБ ХХК – Дотоод хяналтын газрын захирал

**Зээлийн газрын захирал Н.Гантулга**

**Боловсрол:**

2001-2005 он: ШУТИС– Математик загварчлал

2011-2012 он: Газарчин Их Сургууль – Бизнесийн удирдлагын магистр

**Туршлага:**

2014 –2015 он: Аварга Соёо ХХК – Менежер

2015-2019 он: Бичил Глобус Групп ХХК – Зээлийн менежер, Салбарын захирал

2019-2021 он: Бичил Глобус Групп ХХК – Салбарын удирдлагын мэргэжилтэн

2021- Одоо хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК –Зээлийн газрын захирал

**Зээлийн эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Өнөболд**

**Боловсрол:**

2006-2010 он: СЭЗИС – Бизнесийн эдийн засагч

**Туршлага:**

2011-2013 он: ММREC ХХК – Судалгааны мэргэжилтэн

2013-2015 он: Капитал банк – Зах зээлийн эрсдэлийн шинжээч

2015-2018 он: Богд банк – Ахлах эрсдэлийн шинжээч

2018-2022 он: Хаан банк- Зээлийн эрсдэлийн шинжээч

2022-2023 он: Нэткапитал ББСБ – Ахлах эрсдэлийн шинжээч

2023 – Одоо: Бэрс Финанс ББСБ – Эрсдэлийн удирдлагын газрын захирал

**Санхүү бүртгэлийн газрын захирал Б.Тамир**

**Боловсрол:**

2006-2010 он: Их Засаг Олон улсын их сургууль

**Туршлага:**


2012-2014 он: Борнуур Хаан банк – Теллер

2014-2015 он: Бичил Глобус ХХК - Касс менежер

2015-2020 он: Бэрс Финанс ББСБ – Нягтлан бодогч

2020-2023 он: Бэрс Финанс ББСБ – Ерөнхий нягтлан бодогч

2023-Одоо: Бэрс Финанс ББСБ – Санхүү бүртгэлийн газрын захирал







**Bers ABS**  
loyalty

БҮРТГЭВ-03

Үнэт цаасны танилцуулга



#### Үйл ажиллагааны газрын захирал Д.Урангоо

##### Боловсрол:

2000-2004 он: Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль – Эконометрик

##### Туршлага:

2005-2009 он: Анод банк – Теллер

2010-2012 он: Хадгаламж банк – Салбарын эрхлэгч

2012-2014 он: Чандмань илч ОНӨААН – Нягтлан бодогч

2016-2017: Бичил глобус финанс ББСБ – Хянагч нягтлан бодогч

2017-2020 он: Бичил глобус ХХК- Санхүүгийн мэргэжилтэн

2020-2023 он: Бэрс финанс ББСБ – Нягтлан бодогч

2023-Одоо: Бэрс финанс ББСБ – Үйл ажиллагааны газрын захирал

#### Бизнес хөгжлийн газрын захирал Б.Даваабат

##### Боловсрол:

2006-2008 он Соёлын коллеж– Компьютерийн оператор

2008-2011 он СУИС – Соёлын арга зүйч

##### Туршлага:

2011–2012 онд Хийморь Принтинг ХХК – Ахлах дизайнер

2012-2016 онд Креатив Пролайн ХХК – Бренд менежер, Креатив директор

2016-2021 онд Бичил Глобус ХХК – Маркетингийн Менежер

2021-Одоо: Бэрс Финанс ББСБ ХХК – Маркетингийн хэлтсийн захирал, Бизнес хөгжлийн газрын захирал

#### Хөгжүүлэлтийн инженер О.Батжаргал

##### Боловсрол:

1996-1999 он: ШУТИС – Программ хангамжийн инженер

##### Туршлага:

1997-2000 он: Алтан Тариа ХХК - Программист

2002-2015 он: Оюуны Өмчийн Газар – Мэргэжилтэн


2016-2021 он: Төрийн Банк – Программ зохиогч

2021 -Одоо: Бэрс Финанс ББСБ ХХК – Мэдээлэл технологийн инженер

#### 4.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн засаглалын кодекс

Бэрс Финанс ББСБ ХХК нь Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж, кодексийн зарчмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал, түүнийг төлөөлөх Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн эрх үүргийг тодорхойлон олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлагналыг бэлтгэн, дотоод болон хөндлөнгийн аудитын хяналт шалгалт, дотоод хяналт, зохицуулагч байгууллагаас шаардах эрсдэлийн удирдлагын зохистой хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллахыг зорьж байна. (ТУЗ-ийн 2023 оны 1-р сарын 4-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолоор холбогдох багц журмууд, бодлогын баримт бичгүүдийг баталсан.)

**Кодексийн 1-р зарчмыг** хэрэгжүүлэх хүрээнд “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан ба тус журамд ТУЗ-ын бүрэн эрх, ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн





даргын чиг үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага, хариуцлагыг нарийвчлан, ТУЗ-ын гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэх үйл ажиллагааг тус журмаар мөн зохицуулсан ба "Залгамж халааны бодлого"-ын баримт бичигт шаардлагатай зохицуулалтыг тусгасан.

**Кодексийн 2-р зарчим:** "ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам"-ын 2-р бүлэгт Аудитын хороо; 3-р бүлэгт нэр дэвшүүлэх хороо; 4-р бүлэгт цалин урамшууллын хороо; 5-р бүлэгт Эрсдэлийн удирдлагын хорооны бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг, гишүүдэд тавигдах шаардлага болон бусад зохицуулалтыг тус тус нарийвчлан тусгаж хороодын хурлыг зохион байгуулах зохицуулалтыг оруулсан.

**Кодексийн 3-р зарчим:** "Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам"-д олон нийтэд хүргэх мэдээлэл, санхүүгийн болон санхүүгийн бус тайлан мэдээлэл, мэдээлэх арга хэрэгсэл болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг оруулсан.

**Кодексийн 4-р зарчим:** Аудит хяналтын тогтолцооны хараат бус үр дүнтэй байдлыг хангах хүрээнд "ТУЗ-ын дэргэдэх хороодын журам"-ын 2-р бүлэгт, "Дотоод хяналт аудитын журам", "Хөндлөнгийн аудитыг сонгох журам"-уудад холбогдох зохицуулалтыг тусгасан.

**Кодексийн 5-р зарчим:** Эрсдэлийн удирдлага, комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, үр дүнд хяналт тавих хүрээнд "Эрсдэлийн удирдлагын бодлого, журам" болон ТУЗ-ын дэргэдэх эрсдэлийн хорооны үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүнийг холбогдох журамд тусгасан. Шаардлагатай мэдээллийг үйл ажиллагааны тайланд тусгаж нийтэд мэдээлэхээр төлөвлөсөн.

**Кодексийн 6-р зарчим:** Эрх бүхий албан албан тушаалтны цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод тогтох зарчмыг мөрдлөг болгох үүднээс ТУЗ-ын дэргэдэх хороодын журмын 4-р бүлэг, ТУЗ-ын үйл ажиллагааны журмын 8-р бүлэгт тус тус холбогдох заалтуудыг тусгасан.

**Кодексийн 7-р зарчим:** Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, хамтран ажиллах ажиллах байгууллагын соёлыг "Оролцогч талуудтай хамтран ажиллах журам"-д тодорхойлон тусгаж, үйл ажиллагааны тайланд хамтран ажилласан стратеги, журмын хэрэгжилтийг тайлагнах талаар холбогдох журамд тусгасан.

**Кодексийн 8-р зарчим:** Компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоох зорилгоор хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах, аливаа зөрчлийг мэдээлэх тухай "Ёс зүйн дүрэм"; "Шүгэл үлээх журам"-д тусган оруулсан.

**Кодексийн 9-р зарчим:** Хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хүндэтгэн тэгш хандах, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангах хүрээнд компанийн үйл ажиллагаа санхүү, засаглал, гүйцэтгэлийн үр дүнгийн талаар мэдээлэх, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх үйл ажиллагааг "Ил тод байдлын журам"; "Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам"; "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам"; "Сонирхлын зөрчлийн зохицуулах журам" зэрэг журмуудад холбогдох заалтуудыг тусган баталсан ба журмын хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан.





**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

2023.12.22

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүний нөөц, программ хангамжийн тухай**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, Дотоод хяналтын газрын захирал болон ТУЗ-ийн гишүүд нь санхүүгийн салбарт олон жилийн мэдлэг боловсрол, туршлагатай бөгөөд санхүүгийн салбарт нэг ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байна.

Программ хангамжийн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь олон жилийн туршлагатай программ хангамжийн үйлчилгээ үзүүлэгч Грэйпсити Монгол ХХК-ийн хөгжүүлсэн нягтлан бодох бүртгэлийн "Поларис" үндсэн системийг санхүүгийн болон санхүүгийн бус бүх төрлийн гүйлгээ, бүртгэл хийх, холбогдох тайлангуудад хяналт тавих зэрэгт ашигладаг.

Мөн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Үнэт цаас гаргагчид худалдах зээлийн багцын данс бүртгэлийг хөтлөх, гүйлгээ хийх, холбогдох тайлан бэлтгэж, хянах үйлдлүүдийг өөр тусдаа систем болох "Зээл худалдах систем (Securitization modul)" модулийг ашиглаж хийнэ. Үнэт цаас гаргагч нь 2023 оны 11-р сарын 16-ны өдөр "Грэйпсити Монгол" ХХК-тай ЛА-23/69 тоот "Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ" байгуулсан ба гэрээний дагуу Грэйпсити Монгол ХХК нь Поларис үндсэн системтэй хоршин ажиллах, зээл худалдах системийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлж, гэрээ дуусгавар болох хүртэл системийг түрээсээр ашиглуулна. Тус гэрээний дагуу Грэйпсити Монгол ХХК нь системийн тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, системийн сайжруулалт, засвар үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.

Иймд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөц болон программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан болно.

**Поларис системийн тухай:** "Зээл худалдах систем" модулийг Поларис системд интеграци хийж холбосноор дээрх 2 систем хоорондоо хоршиж ажиллах боломжтой. Зээл худалдах модуль нь "Грэйпсити Монгол" ХХК-ийн хөгжүүлсэн "МИК" ОССК-ийн банкнуудаас зээл худалдан авахад ашигладаг программ хангамж юм.

Модуль программ нь зээл худалдах болон худалдан авахтай холбоотой гэрээ болон зээлийн мэдээллийг бүртгэлжүүлж тэдгээртэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг хийх зорилго бүхий модуль юм.

**Модулийн үндсэн бизнес процесс:** Бүтээгдэхүүний бүртгэлийг ашиглаж зээл худалдах/худалдан авах гэрээлэх үйл ажиллагааг данс болгон бүртгэдэг. Данс бүртгэхийн тулд бүтээгдэхүүнийг урьдчилан тодорхойлж өгөх хэрэгтэй. Бүтээгдэхүүний бүртгэл дээр уг бүтээгдэхүүн дээр мөрдөгдөх тохиргоог хийнэ.

Бүтээгдэхүүний төрөл : Зээл худалдахад үүрэгтэй/үүрэггүй гэрээлэхийг тодорхойлно.

Үүрэггүй худалдсан багц – Худалдсан зээлийн үүргийг байгууллага үүрэхгүй худалдаж авсан санхүүгийн байгууллага үүрнэ. Худалдсан зээлийг байгууллага балансаас хасаж зээлийн үлдэгдэл болон хүү балансын гадуур хөтлөгдөнө. Байгууллага зөвхөн эргэн төлөлтийг санхүүгийн байгууллага руу шилжүүлнэ. /"Бэрс Эй Би Эс лоялти ТЗК" ХХК нь үүрэггүй худалдах бүтээгдэхүүнийг сонгоно/

• Баримт бичгийн хадгалалт хамгаалалт:

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, ТЗК-тай тулган баталгаажуулах болон хөрөнгө солих, зээлийн баримт бичгийг ТЗК-д хүргүүлэх хүлээн авах зэргээр хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, ТЗК-г хариуцсан эрх бүхий ажилтныг томилж ажиллуулна.





2023.12.25

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд хөрөнгийн багцын дараах баримт бичгүүдийг өөрийн оффис дээр хадгалж хамгаална. Үүнд:

- Хөрөнгийн багцыг бүрдүүлж буй бүх зээлийн баримт бичгүүд;
- Зээлдэгчээс гаргасан хүсэлт, захидал харилцаа.

**Схем 3: Поларис системийн үндсэн бизнес процесс**







#### 4.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн байдал

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гол үйл ажиллагаа нь зээлийн үйлчилгээ бөгөөд дараах төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад санал болгож байна.

##### Зээлийн бүтээгдэхүүн:

- 1) Автомашин барьцаалсан зээл
- 2) Автомашин худалдан авах лизингийн зээл
- 3) Дугаар барьцаалсан зээл
- 4) Хашаа байшин, объект барьцаалсан зээл
- 5) Газар, граж барьцаалсан зээл
- 6) Орон сууц барьцаалсан зээл
- 7) Унах автомашин барьцаалсан зээл



Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өнгөрсөн тайлант жилүүдийн аудитын тайлан болон 2023 оны 3-р улирлаар Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнасан тайланг ашиглан доор санхүүгийн мэдээллийг бэлтгэсэн болно. Аудитын тайлангийн загвар болон СЗХ-ны загварын зөрүүгээс үүдэн хүснэгт ялгаатай харагдах боломжтой. “Бэрс Финанс ББСБ” ХХК нь 2022 оноос эхлэн дэлхийн топ 4 аудитын компанийн нэг болох Кэй Пи Эм Жи Аудит Монголиа ХХК-аар санхүүгийн тайлангийн аудит хийлгэсэн байна.

#### Хүснэгт 19: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүү байдлын тайлан, сая төгрөгөөр

(сая төгрөг)	2020 аудит	2021 аудит	2022 аудит	2023Q3
Мөнгөн хөрөнгө	587.8	2,802.6	7,010.0	2,632.6
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	-	-	1,810.0	-
<b>Зээл /цэвэр/</b>	<b>17,500.0</b>	<b>29,566.5</b>	<b>38,072.0</b>	<b>50,802.1</b>
Нийт зээл	17,995.5	29,928.1	38,363	51,160.6
(Зээлийн эрсдэлийн сан)	(495.5)	(361.6)	(291.0)	(358.5)
Бусад авлагууд	105.4	5.4	-	981.9
Бусад хөрөнгө	1,024.0	9,297.7	6,423.0	385.1
<b>Эргэлтийн хөрөнгийн нийт дүн</b>	<b>19,217.2</b>	<b>41,672.2</b>	<b>53,024.0</b>	<b>54,801.6</b>
Үндсэн болон биет бус хөрөнгө	485.3	487.6	726.0	1,369.2
Биет бус хөрөнгө	-	-	-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>485.3</b>	<b>487.6</b>	<b>726.0</b>	<b>1,369.2</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,702.5</b>	<b>42,159.8</b>	<b>53,750.0</b>	<b>56,170.8</b>
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	-	-	9,180.0	6,343.8
Өрийн бичгээрх өглөг	1,116.0	4,200.0	10,000.0	6,500.0
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	-	-	-	-
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	7.9	3,950.9	5,526.0	7,979.0
Орлогын албан татварын өр төлбөр	-	-	-	460.8




Бусад өр төлбөр	1,238.6	1,459.8	3,421.0	2,652.5
Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	630.0	-	-	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>2,992.5</b>	<b>20,301.5</b>	<b>28,127.0</b>	<b>23,936.1</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>				
Хувьцаат капиталын дүн	6,090.0	6,090.0	6,090.0	6,090.0
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	10,620.0	15,768.0	19,533.0	26,144.7
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>16,710.0</b>	<b>21,858.0</b>	<b>25,623.0</b>	<b>32,234.6</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,702.5</b>	<b>42,159.5</b>	<b>53,750.0</b>	<b>56,170.8</b>


Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

**Хөрөнгө:** 2020 оноос 2023 оны 3-р улирал хүртэл үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2.8 дахин өсөж 56.2 тэрбум төгрөгт хүрээд байна. Уг өсөлтөд нийт хөрөнгийн 91 хувийг бүрдүүлж буй цэвэр зээлийн багц 2.8 дахин өссөн нь шууд нөлөөлсөн байна.

**График 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө, сая төгрөгөөр**




**График 3: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр зээл, сая төгрөгөөр**




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

**Зээл:** Бэрс Финанс ББСБ нь 2023 оны 3-р улирлын байдлаар 6,745 зээлдэгчийн нийт 51.1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан. Өөрөөр хэлбэл нэг зээлдэгчийн дундаж зээлийн хэмжээ 7.6 сая төгрөг байна.

Топ-40 зээлдэгчид олгосон нийт зээлийн үлдэгдэл 10.2 тэрбум төгрөг бөгөөд нийт зээлийн багцын 19.8 хувийг бүрдүүлжээ. Эдгээр зээлдэгчийн хамгийн өндөр дүнтэй зээл нь хуулийн этгээдэд олгосон 2.6 тэрбум төгрөгийн зээл бөгөөд энэ нь үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн 8.1% тай тэнцэх юм.


**График 5: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багцын чанар**


- Энгийн зээл
- Анхаарал хандуулах
- Чанаргүй зээл

**График 6: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн чанаргүй зээлийн хувь**


Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

2023 оны 3-р улирлын байдлаар хэвийн зээлийн нийт зээлд эзлэх хувь 97.2% байна. Харин чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 1.28% байсан байна. Энэ оны 2-р улирлын салбарын тайлангаар ББСБ салбарын чанаргүй зээлийн хувь 7.7% байснаас харахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багцын чанар салбарын дунджаас үзүүлэлттэй байна. “Бэрс финанс ББСБ” ХХК нь цахим бус, уламжлалт зээл олголтод төвлөрдөг, автомашины фидуцийн зээл голчлон олгодог зэрэг нь зээлийн эргэн төлөлт сайн байх үндсэн хөшүүрэг болдог байна. Үнэт цаас гаргагч нь Хорооноос шаардсан журмын дагуу зээлийн багцыг ангилан зээлийн эрсдэлийн сан байгуулан ажилладаг ба 2023 оны 3-р улирлын байдлаар 358.5 сая төгрөгийн сан бүртгэсэн. Энэхүү дүн нь нийт зээлийн 0.7%-тай тэнцэнэ. 2023 он гарснаас хойш 211.2 сая төгрөгийн эрсдэлийн сангаас зардал бүртгэсэн байна.

**График 7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн жигнэсэн дундаж хүү**


Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

Зээлийн жигнэсэн дундаж хүү 2020 оны 4 дүгээр улиралд 3.8 хувь байсан ба 2022 эцсийн байдлаар Бэрс Финанс ББСБ-ын зээлийн жигнэсэн дундаж хүү буурч, 2023 оны 3-р улирлын дүнгээр зээлийн жигнэсэн дундаж хүү 3.2 хувь буюу өмнөх оны түвшинд хадгалагдаж байна. Харин хамгийн дээд хэмжээ нь сарын 3.9 хувь, доод хүү нь 2.1 хувь байна.


**Эх үүсвэр:** 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтцийн 52 хувийг өр төлбөр, 48 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байв. Харин 2023 оны 3-р улирлын байдлаар өр төлбөр нийт хөрөнгийн 42.6 хувь, өөрийн хөрөнгө үлдсэн хувийг бүрдүүлж байгаа буюу өөрийн хөрөнгийн эзлэх хувь хэмжээ өссөн байна. Тайлант хугацаанд цэвэр ашгийн өсөлт өндөр байгаа нь хуримтлагдсан ашгийг






өсгөж, цаашлаад өөрийн хөрөнгө өсөх үндсэн шалтгаан болж байна. ББСБ-уудын хувьд өөрийн хөрөнгийн хэмжээ өндөр байх нь эрсдэл даах чадварыг нэмэгдүүлдэг тул нэмэлт хөшүүрэг ашиглах байдлаар орлого болон ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх илүү боломжтой болдог.

**График 8. Эх үүсвэрийн бүтэц, 2023Q3, сая төгрөгөөр**



**Хүснэгт 20. Орлого, үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр**

(сая төгрөг)	2020 аудит	2021 аудит	2022 аудит	2023Q3
Хүүгийн орлого	8,604.0	9,870.2	15,057.0	13,336.7
Хүүгийн зардал	1,087.5	933.1	4,261.0	2,925.4
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>7,516.5</b>	<b>8,937.0</b>	<b>10,796.0</b>	<b>10,411.3</b>
<b>Хүүгийн бус орлого</b>	<b>83.6</b>	<b>67.6</b>	<b>349.0</b>	<b>789.8</b>
Арилжааны цэвэр орлого	-	-	-	-
Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	-	-	-
Санхүүгийн үйлчилгээний шимтгэл	83.6	67.6	206.0	229.9
Бусад орлого	-	-	143.0	559.8
<b>Хүүгийн бус зардал</b>	<b>2,213.9</b>	<b>3,130.9</b>	<b>5,076.0</b>	<b>3,585.2</b>
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	-	-	-	-
Боловсон хүчний холбогдолтой зардал	1,658.9	2,268.8	3,629.0	2,390.6
Бусад зардал	555.0	862.1	1,446.0	1,194.6
<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-2,130.3</b>	<b>-3,063.4</b>	<b>-4,727.0</b>	<b>-2,795.4</b>
<b>Сан байгуулахаас өмнөх ҮА ашиг/алдагдал</b>	<b>5,386.2</b>	<b>5,873.7</b>	<b>6,069.0</b>	<b>7,615.9</b>
<b>Болзошгүй эрсдэлийн зардал</b>	<b>402.1</b>	<b>137.7</b>	<b>103.0</b>	<b>211.2</b>
Зээлийн эрсдэлийн зардал	402.1	137.7	103.0	211.2
Найдваргүй авлагын нөөцийн зардал	-	-	-	-
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал	-	-	-	-
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ</b>	<b>4,984.1</b>	<b>5,736.0</b>	<b>5,966.0</b>	<b>7,404.7</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	3.9	-	15.0







**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

СЗХ


ОН... сар... өдөр  
2023.12.22

Үндсэн бус үйл ажиллагааны зардал	10.0	18.3	4.0	66.7
<b>Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал/</b>	<b>4,974.1</b>	<b>5,721.6</b>	<b>5,962.0</b>	<b>7,353.0</b>
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>4,974.1</b>	<b>5,721.6</b>	<b>5,962.0</b>	<b>7,353.0</b>
Орлогын татварын зардал	499.9	573.6	597.0	741.9
<b>Цэвэр ашиг</b>	<b>4,474.1</b>	<b>5,148.0</b>	<b>5,365.0</b>	<b>6,611.0</b>


Эх сурвалж: “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайлан

**Орлого, зарлага:** “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн орлого 2020-2022 онд жилд дунджаар 20.5 хувиар өссөн байна. Харин тус хугацаанд цэвэр хүүгийн орлого жилд дунджаар 12.8 хувиар өсжээ. Цэвэр хүүгийн орлогод нөлөөлөх гол хүчин зүйл нь сүүлийн жилүүдийн хүүгийн зардлын өсөлт буюу эх үүсвэрт өрийн санхүүжилтийг түлхүү ашигладаг болсонтой холбоотой. Харин 2022 онд хүүгийн зардал нь нийт хүүгийн орлогын 28.2 хувьтай тэнцэж байсан бол 2023 оны 3-р улиралд 21.9 хувьтай тэнцэж байна.

**График 99: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ашигт ажиллагаа, сая төгрөгөөр**



**График 10: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүүгийн орлого, зардал, сая төгрөгөөр**



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг 2019-2022 онд жилд дунджаар 26 хувийн өсөлт үзүүлсэн. Өнгөрсөн онуудад Бэрс-1, Бэрс-2 хаалттай өрийн хэрэгслүүд, энэ онд Бэрс 3 хаалттай өрийн хэрэгсэл гаргаж, түүнчлэн арилжааны банкны зээл ашиглаж байгаатай холбоотойгоор хүүгийн зардал өссөн нь доорх графикаас харагдаж байна.

**График 10. Цэвэр ашиг, сая төгрөгөөр**



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан



**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эх үүсвэрийн төрлүүд:**

**Итгэлцэл:** Бэрс Финанс ББСБ ХХК нь 2023 оны 3-р улирлын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 66 хөрөнгө оруулагчийн, 7.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий итгэлцлийг татсан ба энэхүү дүн нь өөрийн хөрөнгийн 24.8 хувьтай тэнцэж байна. Журмын дагуу ББСБ нь өөрийн хөрөнгийн 80% хүртэлх дүнгээр итгэлцэл татан төвлөрүүлж болдог. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь итгэлцлийг дунджаар 1 жилийн хугацаатай, дунджаар жилийн 18% өртөгтэйгөөр татан төвлөрүүлсэн байна.

**Бэрс 1 хаалттай бонд:** Бэрс Финанс ББСБ ХХК нь 2021-2022 онд нийт 10.0 тэрбум төгрөгийн дүн бүхий "Бэрс-1" бондыг Биржийн бус зах зээл дээр амжилттай арилжаалан, эх үүсвэр татан төвлөрүүлсэн ба тус бондуудын хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хугацаандаа, амжилттай хийгдсэн.

**Бэрс 2 хаалттай бонд:** Харин 2022-2023 оны хооронд Биржийн бус зах зээл дээр санал болгосон нийт 6.5 тэрбум төгрөгийн Бэрс-2 бонд үлдэгдэлтэй байна. Уг бондын хөтөлбөрт үнэт цаас гаргагчийн нийт энгийн хувьцааны 30% хувьцааг барьцаалсан. Бондын транчууд 2023.12 болон 2024.01 саруудад эргэн төлөгдөх хуваарьтай байна.

**Бэрс 3 хаалттай бонд:** 2023 оны 10-р сард Биржийн бус зах зээлээс татан төвлөрүүлсэн нийт 8.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Бэрс-3 бонд нь 2024 онд төлөгдөх хуваарьтай.

**Бэрс ХБҮЦ 1:** Бэрс Финанс ББСБ ХХК -ийн охин компани "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь 2022 оны 8 дугаар сард 10.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Бэрс ХБҮЦ-ийг Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж олон нийтэд нээлттэй хүрээнд амжилттай санал болгож, эх үүсвэр татан төвлөрүүлсэн.

Хуваарийн дагуу 2023 оны 9-р сард эхний 50 хувийг эргүүлэн төлсөн ба үлдэгдэл хэсэг 2024 оны 9-р сард эргэн төлөгдөнө. Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК ажиллаж байна. Андеррайтер Мандал капитал маркетс ҮЦК ажилласан.


**Бэрс ХБҮЦ 2:** Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн охин компани "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь нийт 9.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах гаргах хүсэлт гаргаж холбогдох ХБҮЦ-ийн шийдвэр Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 3-р сарын 31-ний өдөр, Монголын Хөрөнгийн Бирж-ээс 2023 оны 4-р сарын 6-ны өдөр тус тус гарсан. Үнэт цаасны 50% нь 12 сарын дараа эргэн төлөгдөх, үлдсэн хувь нь 24 сарын дараа буюу хугацааны эцэст эргэн төлөгдөх хуваарьтай.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК ажиллаж байна. Андеррайтераар Голомт капитал ҮЦК ажилласан.

**Банкны зээл:**

2023 оны эхний хагас жилийн байдлаар 7,908.9 сая төгрөгийн банк, санхүүгийн байгууллагаас авч ашиглаж буй зээлтэй. Үүнээс 4,352.9 сая төгрөг нь МИК-ээс авсан автомашины багц барьцаалсан санхүүжилт бөгөөд зээлийн барьцаанд барьцаалсан автомашинуудыг жагсаалтаар тодорхой зааж өгсөн. Барьцааны мэдээлэл [mrg.mn](http://mrg.mn)-д орсон байна.

3,400.0 сая төгрөг- Голомт Банкны 3.4 тэрбум төгрөгийн зээлийн шугам бөгөөд уг зээлийн барьцаанд 3 үл хөдлөх, 2 газар мөн нэг автомашин барьцаалсан байна. 155.9 сая төгрөг- 2023 оны 2-р сард Голомт банкнаас авсан автомашины зээл бөгөөд дуусах хугацаа 2028 он. Зээлийн мэдээллийн санд хийсэн хайлтаар эдгээр зээлүүд нь аливаа хугацаа хэтрэлт байхгүй, хэвийн ангилалтай байна.



**Хүснэгт 21: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гаргасан үнэт цаасны мэдээлэл**


Үнэт цаас	Огноо	Үнийн дүн \тэрбум төгрөг\	Эргэн төлөгдсөн байдал	Барьцаа хөрөнгө
<b>Хаалттай (Биржийн бус заах зээл буюу ОТС)</b>				
Бэрс -1	2021.12-2022.01	10.0	Төлөгдөж дууссан.	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багц, хувьцаа, дансны орлого
Бэрс - 2	2022.12-2023.01	4.2 2.3	2023.12-2024.01 сард төлөгдөх	Энгийн хувьцааны 30% хувьцаа
Бэрс - 3	2023.10	8.0	2024.10 сард төлөгдөх	5 үл хөдлөх, хувьцаа эзэмшигчийн баталгаа, энгийн хувьцааны 50%
<b>Нээлттэй (МХБ)</b>				
<b>Бэрс ХБҮЦ-1</b> "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн үнэт цаас	2022.09	5.0	2024.08 сард төлөгдөх	Автомашини фидуци бүхий зээлийн багц тусгаарласан. 50,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хүү жилийн 16.8%. (2023.10.31-ны байдлаар багцын үлдэгдэл 5.77 тэрбум төгрөг).
<b>Бэрс ХБҮЦ-2</b> "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн үнэт цаас	2023.04	9.0	2025.04 сард төлөгдөх	Автомашини фидуци бүхий зээлийн багц тусгаарласан. Нэрлэсэн үнэ 100,000 төгрөг. Хүү 19.2%. (2023.10.31-ны байдлаар багцын үлдэгдэл 8.31 тэрбум төгрөг).

**4.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зохистой харьцаа болон салбарт эзлэх хувь**

**Зохистой харьцааны үзүүлэлт:** ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын дагуу ББСБ-ын үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан тооцох, үнэлэх, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоож, түүний биелэлтийг хянадаг. ББСБ нь үйл ажиллагааныхаа эрсдэлийг үнэлэх, хянахын тулд Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур болон холбогдох хууль тогтоомжийг дотооддоо мөрдөн ажилладаг.

**Хүснэгт 22. Үнэт цаас гаргагчийн зохистой харьцаа үзүүлэлтүүд**

	2020	2021	2022	2023Q
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 10%<	86.9%	54.8%	49.7%	55.3%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 20%<	86.9%	54.8%	49.7%	55.3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 8%<	24.9%	13.8%	24.9%	11.1%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа <80%	0.0%	18.1%	21.6%	24.8%
Өрийн бичгийн зохистой харьцаа <50%	6.7%	19.2%	39%	<b>20.2%*</b>
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа <15%	2.5%	1.2%	1.3%	2.4%







2023.12.22

2023 25

ROA

11.2% 12.3%

ROE

22.6% 23.2%

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ санхүүгийн тайлан

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 2023 оны 3-р улирлын тайланг гаргасны дараа нийт 8.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий “Бэрс бонд-3”-г биржийн бус зах зээлд санал болгож арилжаалсан бөгөөд уг өрийн хэрэгслийг зохистой харьцааны тооцоололд оруулбал “Өрийн бичгийн зохистой харьцаа” нь **45%** болно. Энэ нь Хорооноос баталсан Өрийн бичгийн зохистой харьцааны шалгуурт нийцэж буй үзүүлэлт юм.

**Салбарт эзлэх хувь:** 2023 оны 2-р улирлын байдлаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь нийт хөрөнгийн хэмжээгээр ББСБ-ын салбарын 1.34 хувийг, зээлийн багцын хэмжээгээр 1.49 хувийг, орлогын хэмжээгээр 1.9 хувийг, цэвэр ашгийн хэмжээгээр 1.99 хувийг тус тус бүрдүүлж байна.

**Хүснэгт 23: Үнэт цаас гаргагчийн салбарт эзлэх хувь**

Үзүүлэлт	Эзлэх хувь	Үзүүлэлт	Эзлэх хувь
1 Нийт хөрөнгө	<b>1.34%</b>	4 Нийт итгэлцэл	<b>1.24%</b>
2 Цэвэр зээл	<b>1.49%</b>	5 Өөрийн хөрөнгө	<b>1.19%</b>
3 Хүүгийн орлого	<b>1.90%</b>	6 Цэвэр ашиг	<b>1.99%</b>

Эх сурвалж: СЗХ-ны тайлан, Голомт капитал ҮЦК тооцоолол

Үнэт цаас гаргагч нь зах зээлд тэргүүлж буй бусад нээлттэй ББСБ болон салбарын дундажтай харьцуулахад цэвэр хүүгийн орлогын ахиуц бага байна. Өөрөөр хэлбэл хүүгийн зардал өндөр байгааг илтгэнэ. Харин цэвэр ашгийн ахиуц дунджаас өндөр байгаа нь өрийн эх үүсвэр татсанаар нэмэлт ашиг олж чадаж буйг илтгэнэ.

**График 11: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ба салбарын харьцуулалт, 2023Q3 дүнгээр**





ИГО  
НОЯ  
2023  
БҮРТГЭВ-03

СЗХ  
ОН... СӨР... АЛД  
БҮРТГЭВ  
2023.12.22

# ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

---





**5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ**

**БҮРТГЭВ-03**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар үйлчилгээ үзүүлэгч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна. Мөн хуулийн 19.8 дахь хэсэгт заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болно.



**БЭРС ФИНАНС**

Үнэт цаас гаргагчийн Үйлчилгээ үзүүлэгчээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу "Бэрс финанс ББСБ" ХХК ажиллах ба Үйлчилгээ үзүүлэгч нь хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан, компанийн засаглалын өөрийн үнэлгээ хийж, Санхүүгийн зохицуулах

хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан зарчмуудыг хэрэгжүүлэх хөтөлбөр батлан ажилладаг хуулийн этгээд юм.

**Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ:** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК, "Бэрс Финанс ББСБ" ХХК, "Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК нарын хооронд 2023 оны 11-р сарын 16-ны өдөр 23/755 тоот "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна. Түүнчлэн Хөрөнгөөр баталгаажсан цаасны тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмыг удирдлага болгоно.

Төлбөр цуглуулах үйл ажиллагаа нь төлбөр буюу зээлийн эргэн төлөлтийг цуглуулах, ТЗК-д багцын эргэн төлөлтийг шилжүүлэх гэсэн 2 үе шаттай байна.

**Схем 4: ХБҮЦ-ны төлбөр цуглуулах зураглал**





**Үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг үүрэг:**

- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч эсхүл түүний төлөөлөгчөөс бичгээр ирүүлсэн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйлчилгээ үзүүлнэ;
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн Зээлдэгч, үүрэг гүйцэтгэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн холбогдох Зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө ТЗК-г төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан сард багтааж мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт орсноор Хөрөнгөд багтсан зээлийн багцын шалгуур үзүүлэлт хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу арга хэмжээ авна;
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах, ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хууль ёсны шаардлагаар ТЗК-тай холбоотой аливаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, мэдээллээр хангах, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг бие даан хариуцна;
- Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ТЗК болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ;
- ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг зээлдэгчид хүргүүлнэ;
- Хууль тогтоомжид заасан бусад

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээний дагуу багцын эргэн төлөлтийг хянаж, ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчтэй тогтмол хамтран ажиллана.


**Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцлах нөхцөл**

Гэрээ нь талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусах хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган, Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19.4 заалт болон Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасны дагуу “Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол тусгай зориулалтын компани нь гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй” байна.

Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгоно. Шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд Үйлчилгээ үзүүлэгч Төлбөр цуглуулах үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэгтэй ба ТЗК-аас нэмэлт төлбөр шаардах эрхгүй байна.

Түүнчлэн хуульд заасны дагуу Үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцалсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зориулалтын компанийн сонгож, гэрээ байгуулсан шинэ үйлчилгээ үзүүлэгчид хөрөнгөтэй холбоотой мөнгөн хөрөнгө, нягтлан бодох бүртгэлийн баримт, санхүүгийн тайлан зэрэг бүх материалын эх хувийг цахим хувийн







хамт үнэ төлбөргүй шилжүүлэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь бусдад санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас учруулсан хохирлыг хариуцна.

**Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам:** ТЗК-ийн ТУЗ-аас баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-д талуудын үйлчилгээ үзүүлэх, төлбөр цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. Төлбөр цуглуулахад Үйлчилгээ үзүүлэгч нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.


- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс уюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ.
- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг уг дансанд төвлөрүүлж, дараа сарын 25-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлсэн байна.
- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн, тайлагнана.
- Зээлдэгч зээлийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн болон төлбөл зохих хуваарьт төлбөрөөс давуулан илүү төлсөн бол тухай бүр бүртгэж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдээлэх ба СЗХ-ноос баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг баримлана.
- ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах ажилтыг тусгайлан томилно.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-н төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБУЦ-н болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл, Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэнэ.

**Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ:** Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Барьцаалуулагч (Бэрс Финанс ББСБ ХХК) талуудтай 2023 оны 11-р сарын 16-ны өдөр 23/757 тоот гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээний зорилго нь ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд байгуулагдсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасан зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цугларах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБУЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор Зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд гэрээ болон журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.


Гэрээний дагуу Бэрс финанс ББСБ ХХК нь барьцаалуулагч байх бөгөөд Зээлийн эргэн төлөлтийн дансыг эзэмшиж, худалдсан зээлийн багцын төлбөрүүдийг уг дансанд цуглуулна.

*“Зээлийн эргэн төлөлтийн данс, түүнд цугларсан хөрөнгө нь Барьцаалуулагчийн бусад хөрөнгөөс тусгаарлагдсан, барьцаалуулагчийн бусдын өмнө хүлээсэн аливаа үүрэг, төлбөрийн чадваргүй байдал, дампуурал, татан буулгах ажиллагаанаас ангид байна.”*

Уг гэрээгээр барьцаалуулагч нь гэрээнд тусгасан Зээлийн эргэн төлөлтийн дансыг Үүргийн гүйцэтгэл хангуулагч (Юу Эй Эф Ассет Менжмент ХХК)-д барьцаалж байгаа бөгөөд холбогдох гэрээ, үүргээс бусад байдлаар уг данс дахь мөнгийг бүхэлд нь болон







хэсэгчлэн захиран зарцуулахгүй, зарлагын гүйлгээ хийхгүй байх, зээлийн эргэн төлөлтийн дансанд нөлөөлөх аливаа эрхийн доголдол үүсгэхгүй байх, дансны тайлан мэдээллийг шаардлагатай үед гаргаж өгөх, баталгаажсан өр төлбөр төлөгдөх хүртэл дансыг хаахгүй байх, Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн эрх, эрхээ хангуулах, үйл ажиллагаанд хохирол учруулахгүй байх зэргийг үүрэг хүлээж, баталгаа гаргана.


Гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.





**ЗУРГАА. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН  
УДИРДАГЧИЙН ТУХАЙ**

---



**6. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ**

**6.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ерөнхий танилцуулга**

Олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгож байгаа үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдагч болох “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

“Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Байгууллагын нэр	“Юү Эй Эф Ассет Менжмент” ХХК
Компанийн регистрийн дугаар	2870657
Тусгай зөвшөөрлийн дугаар:	ТЗ 316/18
Гүйцэтгэх захирал	Х.Маргад-Эрдэнэ
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг хүргэн ажилладаг. Компани нь компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн 100 хувь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан, Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан болно.

**Хүснэгт 24: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл**

<b>Гүйцэтгэх захирал</b>	Х.Маргад-Эрдэнэ	МУИС-ийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. Багцын удирдлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилтийн чиглэлээр 13 жил ажиллаж байна. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 05 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
--------------------------	-----------------	---



**Партнер**

Ж.Онон

Лондонгийн Эдийн засгийн их сургуулийг банк, санхүүгийн бакалавр зэрэгтэй төгссөн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилт, компанийн засаглал чиглэлээр 14 жил ажилласан туршлагатай. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн А-07 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан.

**Менежер**

Б.Буяннэмэх

МУИС-ийг эдийн засаг бакалавр, бизнесийн удирдлагын чиглэлээр магистр зэрэгтэй төгссөн. Багцын удирдлага, зээлийн шинжилгээ, үнэт цаасны чиглэлээр 10 дахь жилдээ ажиллаж байна. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан.

Компани нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй гаргасан нийт 118.85 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүргийг гүйцэтгэж, найман Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Эдгээр нээлттэй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хугацааны дундуур борлуулах, дараагийн хөрөнгө оруулагчдад шилжүүлэх боломжтой хөрвөх чадвар бүхий бүтээгдэхүүнүүд юм

**Хүснэгт 25: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажилласан төслүүдийн мэдээлэл**

№	ХБҮЦ гаргагч	Гаргасан огноо	Гаргасан дүн (тэрбум.төг)	ХБҮЦ-ны үлдэгдэл дүн (тэрбум.төг)	Хугацаа	Хэлцлийн зөвлөхөөр ажилласан эсэх
1	"Омни Актив ТЗК" ХХК	2022.03.04	5.00	2.50	24 сар	Үгүй
2	"Симпл Ассет ТЗК" ХХК	2022.06.23	50.00	25.00	18 сар	<b>Тийм</b>
3	"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК	2022.09.02	10.00	5.00	24 сар	<b>Тийм</b>
4	"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК	2022.10.18	10.00	5.00	24 сар	<b>Тийм</b>
5	"ЛэндМН Актив ТЗК" ХХК	2022.11.01	4.85	4.85	24 сар	<b>Тийм</b>
6	"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК	2022.12.19	10.00	7.50	24 сар	Үгүй
7	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК	2023.04.28	9.00	9.00	24 сар	<b>Тийм</b>
8	"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК	2023.06.28	20.00	20.00	24 сар	<b>Тийм</b>
9	"Омни Ассет ТЗК" ХХК	2023 оны 11 сар	6.00*		24 сар	<b>Тийм</b>
<b>Нийт</b>			<b>118.85</b>	<b>78.85</b>		

\*Хүлээгдэж байгаа

БЭРС ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК ХХК  
 АТ 11010710





## 6.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний тухай

Үнэт цаас гаргагч болон "Юү Эй Эф Ассет Менжмент" ХХК нарын хооронд 2023 оны 11 дүгэр сарын 16-ны өдөр хийгдсэн 23/756 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ээр автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд үзүүлэх үйлчилгээ, гэрээний дагуу талууд хамтран ажиллах зарчим, эрх үүргийг зааж өгчээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үйл ажиллагаанд энэхүү гэрээ болон ТЗК-ийн баталсан заавар журмуудыг удирдлага болгоно.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.2**-т заасан ажил үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээнэ.

### Хөрөнгийг эзэмших, удирдах, төлбөр төлөх харилцаа

- ❖ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хариуцах мэргэжилтнийг томилно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмшиж удирдана;
- ❖ Хөрөнгийн багцад хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэрэг өөрчлөлтүүдийг оруулна;
- ❖ Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасны дагуу үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх буюу төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна;
- ❖ Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно.

**Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай:** Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/26а/07 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Өөрчлөлт оруулах үндэслэлийн дэлгэрэнгүйг холбогдох журмаас харна уу.

Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

- Багцын хөрөнгийг солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.

**Солих:** Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, шаардлага хангаж буй шинэ зээлийн хөрөнгөөр солино.

Үүнд:



- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагчаас үзсэн;
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хөрөнгө худалдах худалдан авах гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн.
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж, холбогдох акт үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцно. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжүүлж буй оруулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ нь шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн дүнгийн нийлбэр дүнгээс зөрүүтэй тохиолдолд авлага, өглөгийг тооцоо нийлсэн актад тусгаж, барагдуулна.

**Нэмэгдүүлэх:** Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй буюу Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

Багц дахь зээлийн төлөлтийн мэдээлэлд үндэслэн сард 1 удаа багцын хөрөнгийг нэмэгдүүлэх дүнг гаргаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалтыг харилцан тохирно. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тэдгээр хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж, холбогдох актыг үйлдэж, тооцоог хийснээр хөрөнгийн багцыг нэмэгдүүлж бүртгэсэнд тооцно.

**Буцаан худалдах:** Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл





байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн хөрөнгийг буцаан худалдах акт үйлдэж, буцаан худалдсан зээлийн холбогдох төлбөрийг ТЗК хүлээж авна.

**Хөрөнгө оруулалт:** Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэсгээр дараах зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно. Үүнд:

- Арилжааны банкны хадгаламж
- Монгол улсын Засгийн газар, Монгол банкнаас гаргасан үнэт цаас
- Зохицуулагч байгууллагаас хориглоогүй аливаа хэлбэрийн хөрөнгө оруулалт.

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих:** Талуудын хооронд байгуулсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” болон ТЗК-ийн ТУЗ-аас баталсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-д заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээ авна.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч гэрээнд зааснаар зохих ёсоор гүйцэтгээгүй, гүйцэтгэхийг шаардсан хэдий ч зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй,
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч үүргээ гүйцэтгэхгүй нь тодорхой эсхүл үүргээ биелүүлэх чадваргүй болсон, дампуурах нөхцөл байдал бий болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэт, зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас үнэт цаас эзэмшигч болон ТЗК-д шууд болон шууд бусаар хохирол учирсан,
- Хөрөнгийн багцыг буруу удирдсан, зохих өөрчлөлт оруулаагүйгээс ХБҮЦ-ийн төлбөр хүрэлцэхгүй болсон, ХБҮЦ эзэмшигчид хугацаандаа төлбөр хүлээн авах боломжгүй болсон,
- “Үнэт цаас эзэмшигчид мэдээлэл хүргүүлэх журам”-д заасан хугацаанд удаа дараа мэдээлээгүй.

Эдгээр тохиолдолд гэрээг ТУЗ-ийн шийдвэрээр цуцлах санал гаргах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан Үнэт цаасны болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд буюу шинээр хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах хүртэл ТЗК-ийн ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.

### 6.3. Үнэт цаасны төлбөрийг төлөх төлбөрийн зохицуулалт


ТЗК нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр төлөх бэлэн байдлыг хангана. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа, төлбөр цуглуулах, хүлээн авах үйл ажиллагаанд зориулж оролцогч талууд дараах төрлийн данснуудыг нээлгэж, ашиглана.







**Bers ABS**  
loyalty



**Зээлийн эргэн төлөлтийн данс:**

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Зээлийн эргэн төлөлтийн дансыг зарцуулах эрхтэй этгээд нь үйлчилгээ үзүүлэгч (Бэрс финанс ББСБ ХХК) байна.

Гэхдээ зээлийн эргэн төлөлтийн данс болон түүний мөнгөн хөрөнгийг "Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ"-ээр Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид барьцаална. Зээлийн эргэн төлөлтийн графикт үндэслэн багцын эргэн төлөлтийг цуглуулах ба багцын эргэн төлөлтийг ТЗК руу шилжүүлэх өдөр нь амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдрийн дотор шилжүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний хөлсөө хасаж тооцон, төлбөрийг шилжүүлнэ.

**Төлбөр цуглуулах данс:**

ТЗК нь Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэнэ. Төлбөр цуглуулах данс нь Үйлчилгээ үзүүлэгчийн нээсэн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор ашиглах бөгөөд төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн нэрийн өмнөөс ТУЗ-өөс баталсан журам болон төсвийн дагуу төлбөр цуглуулах данснаас зардал гаргах эрхтэй байна.

**Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх данс:**

ТЗК нь ХБҮЦ-ийг хадгалуулах, ХБҮЦ-ийн төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор ҮЦТХТ дээр гэрээ байгуулж, данс нээлгүүлнэ. Тус үнэт цаасны данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.


Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд уг данс дахь мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан, шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.

ТЗК нь үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрийн төлөлтийг хийхдээ өөрийн харьцдаг брокерын компаниараа дамжуулан ҮЦТХТ дээр нээлгэсэн дансаараа дамжуулан үнэт цаас эзэмшигч нарт холбогдох гүйлгээг хийнэ.


**Хадгаламжийн данс:**

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэсгээр, мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг гэрээ болон хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр байршуулж болно. Үүний тулд хадгаламжийн данс нээлгэн ашиглах бөгөөд энэ данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.

ТЗК-ийн ТУЗ-аас баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д тусгасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь программаар зээлийн төлбөрийг хянах бөгөөд төлбөр цуглуулах данснаас доор дурдсан зарцуулалтыг хийх арга хэмжээг авч, Үнэт цаас эзэмшигчдэд тологдох толборийг зориулалт бусаар зарцуулахаас сэргийлнэ.







**Төлбөр цуглуулах данснаас гарах гүйлгээ:** Түүнчлэн ТЗК-ийн төлбөр цуглуулах данснаас зөвхөн журамд заасан дараах гүйлгээг гүйцэтгэнэ.

1. Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийг ҮЦТХТ-ийн өөрийн данс руу шилжүүлэх
2. Үнэт цаасны хүүгийн орлогын татварыг төлөх
3. Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэх гүйлгээ
4. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах
5. ТЗК-ийн ТУЗ-аас баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий удирдлагын зардал (Эдгээр зардлыг журмын 3.3 хэсэгт тусгайлан зааж өгсөн бөгөөд ТУЗ нь зардлын төсвийг баталж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэнэ. ТЗК нь журамд зааснаас бусад зардал гаргахгүй.)

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журамд зааснаар ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:

- ТЗК-ийн татварын төлбөр;
- ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийн хангуулахтай холбоотой зардал;
- Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал;
- Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин;
- ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
- ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
- Журамд заасан бусад зардал.

**Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө төлөгдөх төлбөр, зардлын мэдээлэл**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө дараах төлбөрүүдийг Үнэт цаас гаргагчийн өмнөөс хариуцаж төлөх бөгөөд Үнэт цаас гаргагчаас тус төлбөрүүдийг нэхэмжлэхгүй. Үүнд:

- Андеррайтерийн үйлчилгээний төлбөр;
- Зээлийн багц нь санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх хөндлөнгийн аудитын тайлангийн үйлчилгээний төлбөр;
- Зээлийн багц нь хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан, хууль зүйн дүгнэлт гаргах үйлчилгээний төлбөр;
- Маркетингийн зардал;
- СЗХ болон МХБ-д бүртгүүлэхтэй холбоотой төлбөр, хураамжууд;
- ХБҮЦ гаргах болон арилжаалахтай холбоотой маркетингийн зардал.





## 6.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программ, хангамж, системийн тухай

“Юү Эй Эф Ассет Менжмент” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцын Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үйлчилгээ үзүүлэгчээс тайлан мэдээлэл хүлээн авах зорилгоор вэбд суурилсан программыг хөгжүүлсэн. Энэхүү программ нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

### 1. Зээлийн мэдээллийг бүртгэх:

- 1.1. Зээлийн хөрөнгийн төрлөөс хамааруулан цахим зээлийн хувьд 15 талбар, автомашины фидуци бүхий зээлийн хувьд 21 талбар мэдээллийг бүртгэнэ.
- 1.2. Багц дахь зээлүүдийн эргэн төлөлтийн хуваарийг бүртгэнэ.

**2. Зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих:** Зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгчээс гэрээнд заасан хугацааны давтамжтайгаар хүлээн авч, тулган баталгаажуулна.

### 3. Багц дахь хугацаа хэтэрсэн зээлийг солих, багцыг нэмэгдүүлэх:

3.1. Зээл солих: 90 хоногоос дээш төлбөрийн зөрчилтэй зээлийг сардаа 1 удаа тооцоо нийлж солих бөгөөд солих нөхцөл үүссэн зээлийн дараах мэдээллийг бэлтгэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдээлнэ:

- Хугацаа хэтэрсэн зээлийн дугаар
- Үндсэн өрийн үлдэгдэл
- Хуримтлагдсан хүү

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дээрх мэдээлэлд үндэслэн хугацаа хэтэрсэн зээлийн нийт дүнд тааруулан ТЗК-д санал болгох зээлүүдийн 1.1-т заасан мэдээллийг программд оруулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-д бүртгэх зээлүүдийг сонгож Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.


3.2. Багцыг нэмэгдүүлэх: Багц дахь зээлүүдийн эргэн төлөлтөд үндэслэн сард 1 удаа багцыг нэмэгдүүлэх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-д нэмж санал болгох зээлүүдийн 1.1-т заасан мэдээллийг программд оруулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-д бүртгэх зээлүүдийг сонгож Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

### Цахим зээлийн хувьд 15 талбар:

### Автомашины фидуци бүхий зээлийн 21 талбар:

№	Талбарын нэр	№	Талбарын нэр
1	Зээлийн дугаар	1	Зээлийн дугаар
2	Зээлдэгчийн овог	2	Гэрээний дугаар
3	Зээлдэгчийн нэр	3	Зээлдэгчийн овог
4	Зээлдэгчийн регистрийн дугаар	4	Зээлдэгчийн нэр
5	Сарын орлого	5	Зээлдэгчийн регистрийн дугаар
6	Зээл олгосон огноо	6	Сарын орлого
7	Төлж дуусах огноо	7	Зээл олгосон огноо
8	Олгосон зээл дүн	8	Төлж дуусах огноо
9	Зээлийн үлдэгдэл	9	Олгосон зээл дүн
10	Зээлийн хүү /сар/	10	Зээлийн үлдэгдэл
11	Зээлийн валют	11	Зээлийн хүү /сар/
12	Сарын төлөлт	12	Зээлийн валют
13	Алданги хувь	13	Сарын төлөлт
14	Зээлийн төлбөр төлж эхлэх огноо	14	Барьцааны төрөл
15	Сард зээл төлөх давтамж	15	Хосолсон барьцаатай эсэх
		16	Хөрөнгийн нэр
		17	ЭЗ барьцааны үнэлгээ
		18	Зээл үнэлгээний харьцаа
		19	Алданги хувь
		20	Зээлийн төлбөр төлж эхлэх огноо
		21	Зээл төлөлтийн төрөл





## 6.5. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨХГҮЙ НӨХЦӨЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.

Хэрэв Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг төлөх чадваргүй болсон тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах бөгөөд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ:

1. Барьцаалуулагч нь Зээлдэгчтэй байгуулсан Зээлийн болон Фидуцийн барьцааны гэрээний дагуу фидуцийн зүйлээс зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Уг үүргийг ТЗК-тай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлнэ.
2. Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 10-д заасан (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу энэхүү гэрээний Барьцаалуулагч үүргээ гүйцэтгэхгүй байх) зөрчлийн улмаас ББСБ нь зээлийн төлбөрийг цуглуулж ТЗК-д шилжүүлэх үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн үед Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д үүснэ.
3. Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д шилжсэнээр тэрээр барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн авч болно. Энэ тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг ТЗК-ийн нэрийн өмнөөс Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ. Барьцаалуулагч төлбөрийн чадваргүй болж, мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь түүнийг барьцааны үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.





## ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН


---











ХБҮЦ-ны өгөөжийн түвшин өндөр тогтох боломжтой байдаг ба эрсдэлээр жигнэсэн өгөөжийн хувьд харьцангуй өндөр.

### Менежмент

Зээлийн багцыг шаардах эрхийг Тусгай Зориулалтын Компанид шилжүүлэхээс гадна хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн багцад хяналт тавьснаар олон талт менежментийн системийг бий болгоно.

### Үнэт цаасжуулалт

Тусгай зориулалтын компани нь ирээдүйн орлогоо барьцаалан шинээр санхүүжилт татах боломжтой байдаг. ХБҮЦ гаргаж татан төвлөрүүлэх дүн нь зээлийн багцад суурилж тодорхойлогддог.

### Эрсдэл

Компанийн зээлийн багцыг салгаж дампуурах эрсдэлийг хязгаарлаж өгдөг хэдий ч багц зээл нь тасалдах эрсдэлтэй. Мөн харилцаанд орж буй талуудын уялдаа холбоог нарийн тодорхойлж өгөөгүйгээс үүдэн үүргийн гүйцэтгэл хангагдахгүй байх, ХБҮЦ-ны эргэн төлөлтийн үйл ажиллагаа тасалдах магадлалтай. Түүнчлэн ТЗК-ийн баталсан журмуудыг баримталж ажиллахгүй байх эрсдэл гарах магадлалтай.

Дотоодын Хөрөнгийн зах зээлд "Монголын Ипотекийн Корпораци ОССК" ХХК 2013 оноос эхлэн ХБҮЦ гаргах үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 32 удаагийн хэлцлээр нийт 4.6 их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийн арилжаалсан байна.

2021 онд "Инвескор ББСБ" ХК, 2022 онд "Омни Актив ББСБ" ХХК, Симпл ассет ТЗК ХХК, Бэрс Эй Би Эс актив ТЗК ХХК, Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК, Лэнд МН актив ТЗК ХХК, Бичил Эй Би Эс актив ТЗК ХХК, 2023 онд Бэрс Эй Би Эс Плас ТЗК ХХК болон "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК нар ХБҮЦ гарган амжилттай арилжаалсан байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь дараах хоёр төрлөөс бүрдэнэ.

1) Баталгаат үнэт цаас, 2) Барьцаат үнэт цаас.

### Хүснэгт 26: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төрөл


1) Баталгаат үнэт цаас		2) Барьцаат үнэт цаас
Үнэт цаас гаргагч	Тусгай зориулалтын компани	Орон сууцны санхүүжилтийн компани, Банк

#### 1) Баталгаат үнэт цаас нь

Хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч, худалдагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасаж, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн үнэт цаас байна.

#### 2) Барьцаат үнэт цаас нь

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан бүртгэгдсэн, орон сууцны зээлийн болон хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, үнэт цаасны танилцуулгад







заасан хугацаанд үндсэн төлбөр, түүний хүүг хөрөнгө оруулагчид төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас байна.

**График 12: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөгжил, Монгол улс**



**Хүснэгт 27: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны давуу болон сул тал**

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Аюулгүй байдал/ Компанийн эрсдэлийг хааж өгсөн/</li> <li>• Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа тасалдах, дампуурсан тохиолдолд ч ХБҮЦ хэвийн төлөгдөнө.</li> <li>• Худалдан авагчдын мөнгөн урсгал орж ирэх хугацаа, төлбөр төлөх дараалал тодорхой</li> <li>• Гэрээлэгдсэн учир эргэн төлөлтийн мөнгөн урсгал орж ирэх эх үүсвэр тодорхой.</li> <li>• Биржээр дамжуулж хугацааны өмнө борлуулах боломжтой өндөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эргэн дуудах нөхцөл Зээлийн багцын төлөлт хугацаанаас өмнө орж ирсэн тохиолдолд ХБҮЦ-ыг эргэн дуудах нөхцөлтэй гаргадаг. Ингэснээр худалдан авсан хөрөнгө оруулагчид хугацаанаас өмнө эргэн төлөлтөө авах магадлалтай. "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн гаргаж буй ХБҮЦ-ны хувьд ХБҮЦ-ны тухай хууль, холбогдох гэрээнд зааснаас бусад тохиолдолд эргэн дуудаж төлөлт хийх нөхцөлгүй тул энэхүү эрсдэлийг хаасан байна.</li> <li>• Бүтцийн эрсдэл ХБҮЦ-тай холбоотой оролцогч талуудын уялдаа холбоог журам бүтцээр зохицуулаагүй тохиолдолд үүргийн гүйцэтгэл хангагдахгүй мөнгөн урсгалд эрсдэл үүсэх</li> </ul>







## 7.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ<sup>1</sup>

Өнгөрсөн онд Монгол Улсын эдийн засгийн гол түнш орон болох БНХАУ-д Тэг-Ковидын бодлогыг хэрэгжүүлснээр томоохон хот, мужуудад хөл хорио тогтоож үйлдвэрлэл, худалдааны эргэлт нь буурсан. Энэ нь уул уурхайн экспортоос ихээхэн хамааралтай манай улсын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн юм. Түүнчлэн 2022 оны 2-р сард гарсан ОХУ-Украины дайн нийлүүлэлтийн тасалдал үүсэж, инфляцын түвшин нэмэгдэж, эдийн засгийн өсөлт удаашрахад нөлөөлсөн. Эдгээр хүчин зүйлтэй холбоотойгоор Монгол улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Монгол Банкнаас бодлогын хүүг 13 хувь болгож шинэчилсэн нь хэвээр хадгалагдаж байна.

### Хүснэгт 28: Монгол улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	2020	2021	2022	2023Q2
<b>Бодит сектор</b>					
ДНБ, оны үнээр	тэрбум төг.	36,958	43,555	52,867	30,495
ДНБ, 2015 оны үнээр	тэрбум төг.	26,655	27,092	28,405	13,630,
зэрэгцүүлэх үнээр					
ДНБ-ний бодит өсөлт	хувь	-4.6%	1.6%	4.8%	6.4%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	11.6	13.3	15.8	-
<b>Мөнгөний сектор</b>					
Мөнгө M1	тэрбум төг.	4,212	6,507	7,201.3	8,189
Мөнгө M2	тэрбум төг.	24,480.7	27,863.5	29,658.8	33,205
Нэгдсэн төсвийн орлого	тэрбум төг.	9,421	12,689	18,600	17,653
Нэгдсэн төсвийн тэнцэл	тэрбум төг.	-4,539	-2,908	-979	2,158
Гадаад валютын албан нөөц	сая ам.дол.	4,774	4,366	3,399	4,124
Нийт гадаад өр	сая ам.дол.	32,362	33,806	33,585	33,790
Засгийн газрын гадаад өр	сая ам.дол.	8,653	8,454	8,009	7,980.7
Гадаадын хөрөнгө оруулалт	сая ам.дол.	24,206	26,281	28,521	29,120
<b>Гадаад сектор</b>					
Экспорт	сая ам.дол.	7,576	9,247	12,538	11,296
Импорт	сая ам.дол.	5,299	6,849	8,704	6,756
Худалдааны тэнцэл	сая ам.дол.	2,277	2,398	3,834	4,541
<b>Хүүгийн түвшин</b>					
Бодлогын хүү	%	6.0%	6.0%	13.0%	13.0%
Инфляцын түвшин	%	2.3%	13.4%	13.2%	10.1%
Шинээр татсан хадгаламжийн хүү, 10-12 сартай	%	11.1%	8.26%	12.79%	12.78%
Шинээр олгосон зээлийн ЖДХ, жилээр	%	15.9%	13.0%	15.1%	16.5%

<sup>1</sup> Ашигласан эх сурвалж: Санхүүгийн тогтвортой байдлын тайлан, Үндэсний статистикийн хороо, Монгол банк

Үзүүлэлт	Нэгж	2020	2021	2022	2023Q2
Төгрөг ам.долларын албан ханш	төг.	2,849	2,849	3,444	3,459

Эх сурвалж: ҮСХ, Мөнгөлбанк


**ДНБ:** Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, стратегийн ач холбогдолтой томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс шууд хамааралтай байдаг.

2011-2012 онуудад экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ дэлхийн зах зээлд өссөнөөр Монгол Улсын эдийн засаг түүхэн дээд түвшиндээ хүрч байсан. Улмаар уул уурхайн экспортын хэмжээ аажмаар буурч, гадаад өрийн дарамт ихэссэнээр эдийн засаг уналтын мөчлөгт орсон. Харин 2017 онд Монгол Улс нь Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын зах зээлд зэс, нүүрсний үнэ өссөнөөр эдийн засаг аажмаар сэргэж эхлээд байсан хэдий ч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засаг 4.6 хувиар агшсан нь 1992 оны шилжилтийн үеэс хойш тохиосон хамгийн том уналт болсон юм.

Энэ онд БНХАУ-ын хилийн боомтууд бүрэн нээгдсэнээс хойш экспорт эрчимтэй өсөж, манай улсын урсгал тэнцэл сайжирлаа. Ялангуяа нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн нь урсгал тэнцэл эерэг гарах гол хүчин зүйл боллоо. <sup>2</sup> Түүнчлэн төлбөрийн тэнцэл сайжирсан нь төгрөгийн ханш сулрах дарамтыг бууруулж, гадаад валютын албан нөөц (ГВАН) өмнөх үеэс өсөв.

Энэ оны 3-р улирлын байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 6.4% өсөж нэрлэсэн дүнгээр 30,495 тэрбум төгрөгт хүрсэн байна.


**График 13: Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар**



Эх сурвалж: ҮСХ

Эдүгээ Ковид-19 цар тахлын үр нөлөө багассан ч олон улсад өрнөж буй үйл явц нь Монгол улсын эдийн засгийн өсөлтийг удаашруулж байна. Түүнчлэн эдийн засгийн өсөлт нь салбарын тэгш бус өсөлт хэвээр байна. Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2023 онд дунджаар 5 хувь, 2024 онд 6 хувиар сэргэнэ гэж таамаглаж байна. .





**Хүснэгт 29: Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар**

	2023Т	2024Т
Дэлхийн банк	5.3%	6.4%
АХБ	5.4%	6.1%
ОУВС	4.5%	5.5%
<b>Дундаж</b>	<b>5%</b>	<b>6%</b>


Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС

**Инфляц:** Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төслөө өргөн барсан бөгөөд инфляцын түвшнийг 6%(±2) хувийн зорилтод түвшинд тогтвортой барих, хатуу бодлогоо үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Өнгөрсөн онд экспортын доголдол, импортын зардлын тэлэлт, тээврийн саатал, инфляц, валютын нөөц буурсан, ОХУ-Украины дайн, эрчим хүчний үнийн өсөлт зэргээс үүдэж мөнгөний хатуу баримтлахаас аргагүй байдалд хүрсэн. 2022 онд Монгол Улсын инфляцын түвшин хамгийн өндөр нь 16.1 хувьд хүрч байв.

Харин 2023 онд эдийн засгийн гол түнш Хятадын эдийн засаг нээгдэж, экспорт сэргэсэн, ЗГ-ын бондын дахин санхүүжилтийг амжилттай хийсэн, Хятадтай хийсэн своп хэлцлийн хугацааг сунгасан зэрэг нь гадаад тэнцлийн дарамтыг зөөлрүүлээд байна. Тэгснээрээ Монгол банкнаас баталсан мөнгөний бодлогын үр нөлөө аажмаар мэдрэгдэж 9-р сарын инфляц 10.1 хувь болж буураад байна.

Хөдөлмөрийн захын голлох үзүүлэлтүүд сайжирч цар тахлын өмнөх түвшинд ойртож, инфляц буурснаар бодит цалин сүүлийн 4 улирал дараалан өссөн, цаашлаад цалин хөлсний өсөлтийн нөлөөгөөр өрхийн дундаж орлого нэмэгдэж байгаа хэдий ч, өрхийн зарлага орлогоос илүү хурдтай өссөн байна. Инфляцын дийлэнх хэсгийг хүнсний бус зардал, тэр дундаа орон сууц, ус, цахилгаан болон тээврийн хэрэгслийн зардлын өсөлт бүрдүүлэв. Цаашид өрхийн орлого, зарлагын зөрүү үргэлжлэн өсвөл зөрүүг зээлээр санхүүжүүлснээр өрхийн өр нэмэгдэж, өрийн дарамтад орох эрсдэлтэй юм.

**График 14: Инфляцын түвшин, хувиар**



Эх сурвалж: Монгол Банк

Монгол Банк, ОУВС, АХБ-ны шинжээчид инфляцын түвшнийг 2023 онд дунджаар 10 хувь, 2024 онд дунджаар 8 хувьд хүрнэ гэж таамагласан билээ.





	2023Т	2024Т
Монгол Банк	7.8%	6.3%
АХБ	10.9%	8.7%
ОУВС	11.2%	8.8%
<b>Дундаж</b>	<b>10%</b>	<b>8%</b>

Эх сурвалж: Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк, Олон Улсын Валютын Сан

**Төсвийн тэнцэл:** 2023 оны 3-р улирлын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төсвийн орлого 17,653 тэрбум төгрөгт, төсвийн зарлага 15,495 тэрбум төгрөгт тус тус хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,158 тэрбум төгрөг буюу эерэг гарлаа. Эдийн засгийн зарим салбаруудын сэргэлтээс шалтгаалан төсвийн тэнцэл сайжирсан байна. Тухайлбал, уул уурхайн салбарын өсөлтийг даган аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад огцом нэмэгдсэн нь төсвийн орлого бүрдүүлэлт эергээр нөлөөлсөн байна. Эдийн засгийн идэвхжил, түүхий эдийн экспортын таатай нөхцөл байдал үргэлжилснээр төсвийн орлого бүрдүүлэлт өндөр байсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 30 орчим хувь нь уул уурхайн салбараас шууд болон шууд бусаар хамаарч байсан ба БНХАУ "Тэг Ковид" бодлогоо цуцлан хилээ нээснээр Монгол Улсын нүүрсний экспорт сэргэсэн нь үүнд голчлон нөлөөлжээ.

**График 15: Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр**



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

**Гадаад худалдаа:** 2023 оны 3 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын нийт экспорт 11,296 сая ам. доллар, нийт импорт 6,756 сая ам.доллар байснаар гадаад худалдааны тэнцэл эерэг гарч төсвийн тэнцэлд эергээр нөлөөлж байна. Гэвч дэлхийн бусад орнуудын геополитикийн хурцадмал байдал, улс төрийн харилцааны тогтворгүй байдал нь түүхий эдийн үнэ, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл зэрэгт тодорхойгүй байдал үүсгэсэн хэвээр байна.








**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

2023.12.22

График 16: Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллароор



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

**Мөнгөний бодлого:** Монгол Банкны Мөнгөний бодлогын хороо мөнгөний бодлогын хүүг 2023 онд 13 хувьд барих төлөвлөгөөтэй байгаа ба 2019 оноос эхлэн мөнгөний бодлого болон макро эдийн засгийн бодлогыг хослуулан ашиглаж байна. Энэ нь хадгаламжийн хүү нэмэгдэх суурь болж байгаа ба арилжааны банкнуудын шинээр татсан 10-12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 12.78 хувьд хүрсэн нь арилжааны банкнууд дахь мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх хүлээлтийг үүсгэж байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, солонгоруулахын тулд гадаадын шууд хөрөнгө оруулалт татах зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ онд Хөгжлийн банк болон засгийн газрын томоохон гадаад өрийг эргэн төлөлт хийсэн. Тиймээс дотоодын зээлийн эх үүсвэр нэмэгдэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж сайжрах, эх үүсвэрийн төвлөрлийг бууруулахын тулд гадаадын банкны салбарыг Монгол улсад нээх, олон улсын банкнуудаас эх үүсвэр татах асуудал чухалд тооцогдож байна.






### 7.3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ<sup>3</sup>

**Үнэлгээ:** Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2016 оноос 2022 оны хооронд жилд дунджаар 29.3 хувиар өсжээ. 2022 оны жилийн эцсээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6,890.4 тэрбум төгрөг хүрсэн бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 10,998.6 тэрбум төгрөгт хүрээд байна. Үүнд томоохон арилжааны банкнуудын IPO, компаниудын өрийн хэрэгслийн идэвхжил голчлон нөлөөлж байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 онд ДНБ-ий 13.2 хувьтай тэнцүү байсан бол энэ оны хагас жилийн байдлаар 36 хувь болж өссөн байна.

**График 17: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөгөөр**



2022 онд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн байсан ч хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 16 хувиар өсөж 6.9 их наяд төгрөгт хүрлээ. Энэ хугацаанд Мон бийф ХК, Сэндли ББСБ, Төрийн банк ХК, Голомт банк ХК, Монголын Хөрөнгийн Бирж ХК-иуд олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгож зах зээл дээрээс нийт 182 тэрбум төгрөгийг босгосон бол 2021, 2022 онуудад Инвекор ББСБ ХК, Омни актив ТЗК ХХК, Симпл ассет ТЗК ХХК, Бэрс Эй Би Эс актив ТЗК ХХК, Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК, Лэнд МН актив ТЗК ХХК, Бичил Эй Би Эс актив ТЗК ХХК зэрэг компаниуд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж зах зээл дээрээс 93.85 тэрбум төгрөг босгосон байна.

#### 2023 оны 2-р улирлын байдлаар нэмж гаргасан үнэт цаас:

##### IPO:

- "Хаан банк" ХК - 183.4 тэрбум төгрөг
- "Худалдаа хөгжлийн банк" ХК - 83.5 тэрбум төгрөг
- "Хас банк" ХК - 35.7 тэрбум төгрөг

##### Нээлттэй бонд:



- "Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК - 8.0 тэрбум төгрөг
- "Ашид капитал ББСБ" ХХК - 20.0 тэрбум төгрөг

##### Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас:

- "Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК - 9.0 тэрбум төгрөг
- "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК - 20.0 тэрбум төгрөг

**Хувьцаат компани:** Хөрөнгийн зах зээлд шинээр нэмж хувьцаа гаргасан болон нэмэлт хувьцаа гаргасан хуулийн этгээдийн тоо жилээс жилд өсөж байна. Гэвч 2020-2021 он буюу ковидын үед эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн хөрөнгийн зах зээлийн идэвх, тэр тусмаа IPO гаргалтын тоо мэдэгдэхүйц буурсан. Харин арилжааны банкуудын IPO нь салбарын өсөлтийг дэмжиж байна. 2023 оны эхний хагас жилд 3


<sup>3</sup> Ашигласан эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо, Санхүүгийн салбарын тойм





арилжааны банк нийт нийт 1,054.1 тэрбум төгрөгийн хувьцааг анхдагч зах зээл дээр санал болгож нээлттэй ХК болсон бол уг салбарт үйл ажиллагаа явуулж буй ҮЦК-ийн тоонд өөрчлөлт ороогүй.

**График 19: Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо**      **График 18: Шинээр бүртгэсэн ХК**



**ТОП 20 индекс:** 2018 оноос 2022 оны хооронд жилд дунджаар 15 хувиар өсөж, 2021 онд оройн цэг болох 49,252 нэгжид хүрсэн бол 2022 онд 37,566 нэгж болон буурч хаагджээ. 2023 оны 11 сарын 03-ны өдрийн байдлаар индекс 36129 болоод байна. Топ-20 индекс багтах хувьцаат компаниудын 39.4 хувь нь аж үйлдвэрийн, 3.8 хувь нь банк санхүү, 18.2 хувь нь уул уурхайн салбарын компаниуд байна. Хэдийгээр зах зээлийн үнэлгээ өссөн хэдий ч хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар өмнөх оноос бууралттай байна.

**График 20: ТОП-20 индекс**




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

**Арилжааны идэвх:** 2023 оны 2 дугаар улиралд нийт 533.9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оны мөн үеэс 1.9 дахин өссөн үзүүлэлт юм. Нийт арилжааны 80.5 хувийг хувьцааны, 4.6 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн, 7.0 хувийг компанийн бондын, 7.9 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна. Арилжаанд оролцогчдын дийлэнх буюу 56.3 хувийг дотоодын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ эзэлж байна.





**График 21: Үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөгөөр**



- Нийт хувьцааны арилжаа 429.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 5.2 дахин, өмнөх оны мөн үеэс 3.8 дахин өсжээ.
- Компанийн бондын арилжаа 37.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин буурчээ.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа 42.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.2 хувиар буурчээ.
- Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа 24.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 дахин өсжээ.





### 7.4. **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ**<sup>4</sup>

2022 оны байдлаар нийт санхүүгийн зах зээлийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор 57 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс банкны салбарын хөрөнгө 46 их наяд төгрөг буюу 80.6 хувийг, хөрөнгийн зах зээл 6.9 их наяд төгрөг буюу 12.1 хувийг, ББСБ салбар 3.5 их наяд төгрөг буюу нийт зах зээлийн 6.1 хувийг, даатгалын салбар 474.9 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг, үлдсэн 187.5 тэрбум төгрөг буюу 0.3 хувийг хадгаламж зээлийн хоршооны салбар бүрдүүлсэн.


**График 22. Санхүүгийн салбарын бүтэц, 2022 он**



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Санхүүгийн Зохицуулах Хороо  
ББСБ-ын салбар нь 2013 оноос эхлэн хурдацтай хөгжиж байна. 2015-2022 онуудад Монгол Улсын эдийн засгийн жигнэсэн нийлмэл өсөлт дунджаар 12.7 хувийн өсөлт үзүүлсэн бол ББСБ салбар дунджаар 31.9 хувь өсөж бодит эдийн засгаас өндөр өсөлт үзүүлсэн байна.


Харин 2023 оны 2 дугаар улирлын байдлаар СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр нийт 522 ББСБ үйл ажиллагаагаа явуулж байгаа ба энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин харилцагчдын тоо давхардсан тоогоор 3.9 саяд хүрсэн нь өнгөрсөн жилээс 18 хувиар буурсан үзүүлэлт болж байна.

**График 23: ББСБ салбарын тоо, харилцагчдын тоо /мянган хүнээр/**



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан

<sup>4</sup> Ашигласан эх сурвалж: СЗХ, Санхүүгийн салбарын тойм





**Активын бүтэц:** 2023 оны эхний хагас жилийн дүнгээр ББСБ салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 24 хувь өсөж, 3.9 их наяд төгрөгт хүрсэн. Энэхүү өсөлтийн дийлэнх хэсгийг зээлийн өсөлтийн нөлөө бий болгосон байна. ББСБ салбарын нийт хөрөнгө нь **Монгол улсын ДНБ-ийн 7.5 хувь, Банкны салбарын нийт активын 8.2 хувьтай** тэнцэж байна. Хөрөнгийн дүнд цэвэр зээл 74.3 хувь, мөнгөн хөрөнгө 13.3 хувь, эргэлтийн бус хөрөнгө 3.3 хувь, бусад хөрөнгө 9.1 хувь тус тус бүрдүүлжээ. Мөн хамгийн өндөр активтай 20 ББСБ нь салбарын нийт активын 50.5 хувь, нийт зээлийн 53.8 хувийг бүрдүүлж байгаа нь томоохон хэмжээтэй ББСБ-ууд салбарын дийлэнх үзүүлэлтийг бүрдүүлж байгааг илтгэж байна.

**График 24: ББСБ салбарын хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр**



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2022

**Зээлийн багц:** ББСБ-ын салбарын нийт зээлийн үлдэгдэл 2022 оны эцэст 2.7 их наяд төгрөгт хүрсэн бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 3.1 их наяд төгрөгт хүрсэн дүнтэй байна. Энэ нь нийт хөрөнгийн 78.5 хувьтай тэнцэж байна. Харин цэвэр зээлийн хэмжээ 2.93 их наяд төгрөг юм. Нийт зээлийн үлдэгдлийн 97.4 хувийг төгрөгөөр олгосон зээл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ эдийн засгийн уналттай он жилүүд болох 2015-2016 онуудад өсөж хамгийн өндөр түвшин буюу 15 хувь хүрч байсан бол 2017-2018 онуудын эдийн засгийн сэргэлтийн үеүдэд эргэн буурч, 2019 онд 9 хувь болсон. 2020 онд ковидын эдийн засгийн хүндрэл, иргэдийн зээл төлөх, худалдан авах чадвар буурснаар чанаргүй зээлийн хувь эргэн өсөж 10% давсан юм.

2022 оны дүнгээр чанаргүй зээлийн хэмжээ 7.6 хувь, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 11.5 хувь байв. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 7.7 хувь, хугацаа хэтэрсэн зээл 3.3 хувь, энгийн зээл 89 хувьтай байна.







График 25: ББСБ салбарын нийт зээл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: ҮСХ, СЗХ ББСБ салбарын тайлан

Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх зээлдэгчдийн ангиллыг авч үзвэл 88.2 хувь нь иргэд, 11.8 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл юм. Олгосон зээлийн зориулалтын хувьд томоохон салбарууд нь 3.8 хувь нь барилга, 8.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 1.6 хувийн байр сууц, хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ, 2.0 хувь нь машин мотоциклын засвар үйлчилгээнд олгогдсон байна. Олгосон болон төлөгдсөн зээлийн дийлэнх буюу ойролцоогоор 82 гаруй хувь нь бусад ангилалтай байна. Эдгээр нь зарцуулалт тодорхой бус хэрэглээний зээлийг авч ойлгож байна.

**Хүснэгт 31: ББСБ салбарын зээлийн зээлдэгчийн ангилал**

Зээлийн ангилал	Олгосон зээл	Төлөгдсөн зээл	Зээлийн үлдэгдэл
Иргэнд олгосон зээл	2.89	90.4%	2.73
Хуулийн этгээдэд олгосон зээл	0.31	9.6%	0.37
Нийт	3.2	100%	3.1

Банк бус санхүүгийн салбарт финтек зээл олгодог нийт 42 ББСБ байгаа бөгөөд зөвхөн технологид тулгуурлаж зээл олгодог 6 байгууллага байна. Мөн нийт зээлдэгчдийн 16.6 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна. Зөвхөн технологид суурилсан зээл олгодог ББСБ-уудын хувьд салбарын нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь бага хэдий ч олгосон болон төлөгдсөн зээлд эзлэх хувь өндөр байгаа нь эдгээр ББСБ-уудын зээлийн эргэлт сайн, богино хугацаатай байдаг гэдгийг харуулж байна.

**Хүснэгт 32. ББСБ салбарын зээлийн хэлбэрийн ангилал**

	Зээлийн дүн /тэрбум төгрөг/	Эзлэх хувь	Зээлдэгчийн тоо	Эзлэх хувь	Дундаж зээл /мян.төгрөг/
Уламжлалт	2,592.3	83.4%	300,650	22.7%	8,622.1
Цахим зээл	515.2	16.6%	1,021,676	77.3%	504.3
Нийт зээл	3,107.5	100.0%	1,322,326	100%	2,350.0


Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо





Тайлант хугацаанд олгогдсон зээлүүдийг хугацаагаар нь харвал 1-2.5 жилийн хугацаатай олгогдсон зээл хамгийн их хувийг эзэлж байна. Мөн 1 сар хүртэл хугацаатай зээл нийт олгогдсон зээлийн 28 хувийг бүрдүүлж байгаа бол 5-аас дээш жил буюу урт хугацаатай зээлүүд бага байна. Түүнчлэн салбарын жигнэсэн дундаж зээлийн хүү сарын 3.3 хувьтай байна.

**График 26: ББСБ салбарт олгогдсон зээлийн хугацаа, сараар**



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2023-II

**Пассивын бүтэц** ББСБ-ын салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 2016-2021 оны хооронд жилд дунджаар 30 хувийн өсөлтийг үзүүлж, 2022 оны эцэст 2.19 их наяд төгрөгт хүрч байсан. Харин 2023 оны эхний хагас жилд нийт пассив 3.9 их наяд төгрөгт хүрснээс үүсвэрийн 62.5 хувийг эздийн өмч, 37.5 хувийг өр төлбөр бүрдүүлж байна.


**График 27: ББСБ салбарын эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр**




Эх сурвалж: СЗХ, ҮСХ

Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 49.6 хувиар өсөж 449.3 тэрбум төгрөг болсон бол дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан өр төлбөр 8.4 хувь өсөж 428.2 тэрбум төгрөг болсон байна. ББСБ-ийн гаргасан өрийн хэрэгсэл мөн өмнөх оны мөн үеэс 21 хувь өсөж 237.9 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 6 хувьтай тэнцэнэ. 2023 оны II улирлын байдлаар 39 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн хэрэгсэл гаргаж, үүнийг 1,594 хувь хүн, хуулийн этгээд худалдан авчээ. Хөрөнгө эх үүсвэрийн бүтцэд хамгийн өндөр өсөлт үзүүлсэн нь төслийн зээл юм.

**Ашигт ажиллагаа** 2023 оны II улирлын байдлаар ББСБ-ууд нийт 520.2 тэрбум төгрөгийн орлого олж, 331.1 тэрбум төгрөгийн зардал гаргаж 189.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Салбарын хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 42 хувь өсөж, 439.1 тэрбум төгрөг болсон бол уг өсөлтөд хамгийн өндөр нөлөө үзүүлсэн







Нь мөнгөн гуйвуулгын орлого болон бусад орлого байна. Түүнчлэн ББСБ-ууд өрийн хэрэгсэл түлхүү ашиглах болсноос үүдэн хүүгийн зардал 40.7 хувь өсөж 60.7 тэрбум төгрөг болжээ.

**График 28: Хүүгийн орлого, зардал, цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр**



ББСБ-уудын хуримтлагдсан ашиг 40.5 хувь өсөж 889.2 тэрбум төгрөгт хүрсэн нь банк бус санхүүгийн салбарын өсөлт эрчимтэй явагдаж байгааг харуулж байна. Гэхдээ хагас жилийн байдлаар 462 ББСБ нийт 903.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 7 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 53 ББСБ 14.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

**Хүснэгт 33: Салбарын ашигт ажиллагааны харьцаа**

	2022-II	2023-II	<1%	<5%	<10%	>10%
Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	8.4%	8.5%	30.8%	25.1%	22.6%	21.5%
Нийт хөрөнгийн өгөөж ROA	5.5%	5.3%	31.4%	29.3%	24.2%	15.1%





**НАЙМ. ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ  
ЗҮЙН ОРЧИН**

---



### **8.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин**

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна” гэж заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон байдаг.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай, Компанийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.


Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахаас гадна дараах хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

- Иргэний хууль;
- Компанийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Компанийн засаглалын кодекс;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам;
- СЗХ-ны Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;
- СЗХ-ны Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам;
- СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам;
- МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам;
- МХБ-ийн Арилжааны журам;
- МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам;
- Холбогдох эрх бүхий байгууллагын тогтоосон бусад дүрэм, журам болон бусад хууль тогтоомж.





**Bers ABS**  
Loyalty



Үнэт цаасны танилцуулга

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагч нь тусгай зориулалтын компани байх ба тус хуульд тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, дүрэмд тусгагдах асуудал, хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх субъектийн талаар тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компанид хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Хорооны зөвшөөрөлгүйгээр үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэхгүй байх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгасан байдаг. Түүнчлэн тус хуулиар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, баталгаат болон барьцаат үнэт цаас гаргах оролцогчдын хоорондын эрх зүйн харилцаа, эрх үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлуудыг тусгайлан зохицуулсан байдаг.


Мөн Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, ТЗК-н удирдлага, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх хэмжээ, ХБҮЦ гаргах тусгай зөвшөөрөл олгох, хүсэлтийг хянах, шийдвэрлэх, барьцаат болон баталгаат үнэт цаас гаргахад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, үнэт цаасны танилцуулгад тусгах мэдээлэл, түүний агуулга, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч, аудит, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, бүрэн эрх, үүргийг тодорхойлж, ТЗК-н мэдээлэл хүргүүлэх тухай харилцааг зохицуулж байна. Журмын 3 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор түүний үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, зарчим, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх болон хөндлөнгийн аудит хийлгэх тухай нарийвчлан зохицуулсан байдаг.

МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-аар ХБҮЦ-ийн хөрөнгийн биржид бүртгэх бэлтгэл ажил, ХБҮЦ бүртгүүлэх хүсэлт гаргах, ХБҮЦ-ны танилцуулгын агуулга, хэлбэр, ХБҮЦ-ийн бүртгэлийн шалгуур, шаардлага, ХБҮЦ гаргагч болон үнэт цаасанд тавигдах шалгуур, шаардлага, шалгуур, шаардлагаас чөлөөлөгдөх, хөнгөлөх үндэслэл, ХБҮЦ бүртгэх, бүртгэхээс татгалзах болон ХБҮЦ гаргагчийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийг тодорхойлж, түүнтэй холбогдох харилцааг зохицуулж байна.

Үнэт цаас гаргагчийн татвар төлөх үүрэг болон хөрөнгө оруулагчийн хүүгийн орлогоос албан татвар суутган төлөхтэй холбоотой харилцааг Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон эрх бүхий этгээдээс баталсан холбогдох журам, зааврын дагуу зохицуулж байна.







## 8.2. Үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын хэмжээнд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа, зах зээлд оролцогчдод хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой бүхий л харилцаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагддаг.



Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрддэг болно. Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдахаас гадна бусад зохицуулагч байгууллагууд буюу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн холбогдох дүрэм, журмаар зохицуулагддаг. Үүнд:

### Хүснэгт 34: ХБҮЦ гаргахтай холбоотой хууль, дүрэм журмууд

Зохицуулагч байгууллага	Хууль дүрэм, журам
<b>Санхүүгийн Зохицуулах Хороо</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам</li> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам</li> <li>• Үнэт цаасны бүртгэлийн журам</li> <li>• Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам</li> </ul>
<b>Монголын Хөрөнгийн Бирж</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам</li> <li>• Үнэт цаасны бүртгэлийн журам</li> <li>• Арилжааны журам</li> <li>• Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам</li> </ul>
<b>Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэт цаасны хадгаламжийн журам</li> <li>• Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам</li> <li>• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх журам</li> </ul>

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар үнэт цаасыг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн багцад тавигдах шаардлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах төрийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллагын эрх хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан байдаг.

Хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 1.5 дахь хэсэгт “Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцаа нь тус тусын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана” гэж заасны дагуу ийнхүү тусгайлсан журмаар зохицуулагдаж байна.



Биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.4 дэх хэсэгт "Биржийн бусад дүрэм журамд өөрөөр заагаагүй бол хувьцаа, өрийн хэрэгслээс бусад үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг тусгайлсан журмаар зохицуулна" гэж заасны дагуу тус журмаар зохицуулж байна.

### **8.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа болон үнэт цаас гаргах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар зохицуулж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь Хорооны журам болон бусад холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулагддаг.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох дараах хууль, дүрэм журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам;
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам;
- Итгэлцлийн үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- Мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам;
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам;
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам;
- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам;
- Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам;
- Бусад.



#### **8.4. БЭРС-3 ХБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт:**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/26a/07 тоот тогтоолоор баталсан.

#### **Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам**

Тус журамд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан. Журамд зааснаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг гэрээний үндсэн дээр ТЗК-ийн үүсгэн байгуулагч (Захиргааны үйлчилгээ үзүүлэгч) гүйцэтгэнэ. Түүнчлэн ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ТУЗ гишүүний шалгуур үзүүлэлт, бүрдүүлэх бичиг баримт, ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, гишүүдийн хүлээх үүрэг, бүрэн эрх, ажиллах зарчим, нөхцөл зэргийг дэлгэрэнгүй оруулж өгсөн байна.

#### **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам**

Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

Компани нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.3-т зааснаар "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн охин компани болохын хувьд "Бэрс Финанс ББСБ" ХХК мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох хөтөлбөр, дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллана.


Түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч талуудаас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг дагаж, мөрдөж ажиллахыг шаардах, шаардлагатай тохиолдолд талуудаас мэдээлэл, тайлан, баталгаа гаргуулан авах үйл ажиллагааг хийнэ.

Энэхүү журмын дагуух чиг үүргийг ТУЗ-өөр дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ нь бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам батлах, эрсдэлийн түвшинтэй уялдуулан дотоод хяналтын хөтөлбөрийг шинэчлэх, эрсдэл үүссэн тохиолдолд арилгах, бууруулах арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

#### **Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам**

Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

Компани нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдийг мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, нээлттэй ил тод зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг хангаж ажиллах ба Хороо, Биржээс баталсан холбогдох журам болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу мэдээллийг үнэн зөв, цаг тухайд нь, агуулгын хувьд хоёрдмол үгтэйгээр, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй.







**Bers ABS**  
loyalty

MONSOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаасны танилцуулга

2023.12.22

**Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам**

Тус журамд хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан. Компани нь эдгээр үйл ажиллагаанд Хороо, Биржээс баталсан холбогдох журам болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг баримтлан ажиллана.

**Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам**

Тус журамд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан. Уг журмаар төлбөр цуглуулах данснаас гарах гүйлгээ, ХБҮЦ болон ТЗК-аас гарах бусад зардлын дараалал, тэдгээрт оролцох, хяналт тавих талуудын оролцоог журамлажээ.

**Хөрөнгө итгэмжлэн удирдах журам**

Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.

Журмаар хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах нөхцөл, өөрчлөлт оруулах арга, дараалал, түүнчлэн сул чөлөөтэй эх үүсвэрийн удирдлага, хариуцлага зэргийг заасан ба хавсралтаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч рүү хөрөнгө буцаан худалдах үед үйлдэх "Хөрөнгө буцаан худалдах тухай мэдэгдэл"-ийг баталжээ.

**Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам**

Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна.

ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотой учирч болох эрсдэлийг дараах байдлаар 3 ангилал ба эдгээр нь:

- Зээлтэй холбоотой эрсдэл
- ХБҮЦ гаргах оролцогч талуудтай холбоотой эрсдэл
- Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл.

Журмаар эдгээр эрсдэлийг удирдах, сэргийлэх арга хэмжээ болон, эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ, сонирхлын зөрчил, тэдгээрийг мэдэгдэх тухай харилцааг мөн зохицуулсан байна.







**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

СЗХ

АТЭР

2023.12.22

## 8.5. ТЗК ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.15 заалт болон 22 дугаар зүйл, 23 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8-р бүлэгт Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий ТЗК-ийн татан буугдах нөхцөл, дарааллыг зааж өгсөн.

“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийн дүрэмд заасны дагуу:

- Компанийн дүрэм нь Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зориулалтын компани болох зөвшөөрлийг авч, дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана.
  - Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
  - Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдаж авсан;
  - Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан;
  - Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд дурдсанаар Тусгай зориулалтын компанийг татан буулгах шийдвэрийг дээр дурдсан үндэслэлээр тусгай зориулалтын компани, эсхүл үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч, эсвэл Хорооны хүсэлтийг үндэслэн шүүх гаргана.

**Хөрөнгө хуваарилах:** Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг дараах дарааллаар хуваарилна.

- 1) Татан буулгах ажиллагааны зардал;
- 2) Үнэт цаасны танилцуулгад заасан дарааллын дагуу хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны төлбөр;
- 3) Хуульд заасан гэрээний дагуу тусгай зориулалтын компаниас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх этгээдийн шаардлага;
- 4) Хуульд заасан гэрээний дагуу авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага
- 5) Дээрх дарааллын дагуу хөрөнгө хуваарилсны дараа үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно.

Түүнчлэн ТЗК болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулагдсан “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-нд **маргаан шийдвэрлэх тухай:**

“Энэхүү гэрээ байгуулагдах үндсэн зорилго болон ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх, арбитр болон төрийн байгууллагад гомдол нэхэмжлэх гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ. Үнэт цаас гаргагчийн эсрэг татан буулгах, дампуурлын хэрэг эхлүүлэхгүй байх зэрэг байдлаар маргаан үүсгэхийг хориглоно” гэж тусгасан байна.






# ЕС. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ

---





**9. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ**


**9.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ**

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 2-р сарын 07-ны өдрийн 2020/06 дугаар тогтоолоор баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2022 оны 6-р сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам болон 2012 оны 02-р сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан Арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн 23/26а/06 тоот тогтоолын дагуу 150,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй Бэрс-3 Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногийн дотор хүлээн авна.

**Схем 6. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө**



**Анхдагч зах зээлийн арилжих арга**

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгох ба захиалга 100 хувь биелсэн тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг хаана.

**Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах**

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.







**Олон нийтэд танилцуулах**


Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээс хойш 3-аас доошгүй өдрийн дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн оролцогч, олон нийтэд зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах, мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

**Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах**

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3-с доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно. Анхдагч зах зээлийн захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.

**9.1.1. Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар**

**Схем 7. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар**



Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

**Мөнгөн хөрөнгө байршуулах заавар**

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн Үнэт цаасны компанийн номинал дансанд мөнгө байршуулна.

Дансны нэр:	ҮЦК-ийн нэр
Дансны дугаар:	ҮЦК-ийн номинал дансны дугаар /Брокероос авах/
Банкны нэр:	Брокероос авах
Гүйлгээний утга:	Нэр, Регистрийн дугаар, Бэрс-3 ХБҮЦ

**Арилжааны шимтгэл**

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.







### 9.1.2. Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч буюу Монгол Улсад байрладаг хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

### 9.1.3. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр үнэт цаасыг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид үнэт цаасыг бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

### 9.1.4. Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжсэн 15.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий автомашины фидуци бүхий зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтөөс бүрдэнэ.

### 9.1.5. Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрхтэй байна:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг МХБ-ийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй;
- Эзэмшиж буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах (үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй болно);
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас эзэмших эрхээ чөлөөтэй арилжаалах, захиран зарцуулах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан үндэслэлээр хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг буцаан худалдах санал гаргах;
- Бусад тохиолдолд Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаас худалдах, худалдан авах эрхээ өөрийн харьцдаг брокер, дилерийн компаниар дамжуулан захиалга өгөх замаар хэрэгжүүлнэ.
- Хууль тогтоомжид заасан бусад.

### 9.1.6. Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг


Үнэт цаас гаргагч нь дараах эрх үүрэгтэй байна.

- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хүү болон үндсэн төлөлтийн график, схемийн дагуу төлбөрийг хуваарийн дагуу төлөлт хийж барагдуулах;






# Bers ABS Loyalty



- Үнэт цаас гаргагч нь зохицуулах байгууллагуудын тогтоосон хүүгийн орлогын татварыг зохих хуулийн дагуу суутган үнэт цаас худалдан авагчид шилжүүлж, татварын төлбөрийг төсөвт төлөх;
- Үнэт цаасны танилцуулга болон хууль, журмыг зөрчиж Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч нь үл маргах журмаар нөхөн барагдуулах;
- Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл явцын мэдээллийг ТЗК-н баталсан хууль журмын дагуу Үнэт цаас эзэмшигчдэд болон эрх бүхий байгууллагад мэдээлэх;
- Хууль тогтоомж, энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үндэслэлээр хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон буцаан худалдах;
- Бусад хууль тогтоомж, гэрээнд тусгагдсан эрх, үүргийг хүлээнэ.





**9.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАНИЛЦУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ**

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад мэдээлэл хүргэхдээ Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмыг баримтлах бөгөөд тус журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон МХБ-ээс гаргасан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журамд нийцсэн байна.

**Хүснэгт 35: Үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээлэл түгээх нь**

Давтамж Тайлагнах хугацаа	Тайлагнах мэдээлэл
<p>Дараа сарын 10-ны дотор хүргүүлнэ. Мэдээлэлд Ингэхдээ СЗХ өөрчлөлт болон үнэт цаас орсон бол эзэмшигчдэд цахим хэлбэрээр мэдээлнэ.</p>	<p>Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт, хөрөнгийн багцын мэдээлэл, тэдгээрийн шинж байдал, хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ, төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, үндсэн төлбөр, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт, санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн тайлан, хууль тогтоомж, энэ журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад.</p>
<p>Улирал бүрийн эхний сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ. Ингэхдээ СЗХ болон МХБ-д цахимаар, болон олон нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх бөгөөд компанийн цахим хуудсанд мөн тайлагнана.</p>	<p>Багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргүүлсэн улирал тутмын тайлан, мэдээлэл зэрэг хамаарна.</p>
<p>Хагас жил тутам олон нийтэд биржийн хуудсанд дээр мөн компанийн цахим хуудсанд тайлагнана.</p>	<p>Хөрөнгийн багцын мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, төлбөр зарлага, хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтын тайлан, хөрөнгө оруулагчид төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө зэрэг орно</p>





2023 12 25

СЗХ болон МХБ-д 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бичгээр болон цахимаар, олон Жил тутам нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх бөгөөд компанийн цахим хуудсанд түгээх үүрэгтэй.

Жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, ҮЦТ-д заасан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан, хөрөнгийн багцад бүртгэгдсэн хөрөнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагчийн сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл.

Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухай үйл явдал болсноос хойш 3 хоногийн дотор СЗХ болон МХБ-д бичгээр олон нийтэд биржийн хуудсанд дээр мөн компанийн цахим хуудсанд тайлагнана.

Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;

ТЗК нь дараах мэдээллийг дараа улирлын 20-ны өдрийн дотор, өөрчлөлт орсон бол ажлын 3 хоногийн дотор тухай бүр Хороо болон хөрөнгө оруулагчид цахим хэлбэрээр мэдээлэх бөгөөд хагас жилийн болон жилийн эцсийн мэдээллийг Хороонд бичгээр ирүүлнэ

Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орох;

Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Биржид тус тус өөрчлөгдсөн тухай

Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (ХБҮЦ-ны нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, гаргасан ХБҮЦ-ыг хугацаанаас нь өмнө буцаан дуудах, нэмэлт үнэт цаас гаргах гэх мэт)-ийн талаарх мэдээлэл;

Бүртгэлтэй ХБҮЦ-ны 10 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн худалдаж авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5 хувиар өөрчлөгдөх тутамд;

Тухай бүр тайлагнах бол ажлын 3 хоногийн дотор тухай бүр Хороо болон хөрөнгө оруулагчид цахим хэлбэрээр мэдээлэх бөгөөд хагас жилийн болон жилийн эцсийн мэдээллийг Хороонд бичгээр ирүүлнэ

ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас зэрэгт өөрчлөлт орох;

Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулах, компанийн дүрэм, холбогдох гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлтийг тусгах;

Үнэт цаас эзэмшигчдийн хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр;

ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох;

Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл;

Эрх бүхий байгууллагаас ХБҮЦ гаргагчид авсан арга хэмжээний тухай;








бүр ажлын 3 хоногт Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, багтаан мэдэгдэнэ. ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд.

### Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмын тухай

“Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам” Монголын хөрөнгийн биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон холбогдох бусад журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй гэж заасан. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь энэхүү Журамд заасан мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба мэдээллийг олон нийт болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид өөрийн болон Биржийн цахим хуудсаар хүргэнэ. Шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг давхар хүргэж болно. “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-ыг хавсралтаас дэлгэрэнгүй үзнэ үү.






### 9.3. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаасжуулах ажиллагаанаас үүдэлтэй зээлийн хөрөнгийн багцын эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл, зээлдэгч зээлийг урьдчилж төлснөөр орлого тасалдах эрсдэл бий болж болзошгүй байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулах зорилгоор Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны II дүгээр сарын 16-ны өдрийн 23/26а/07 тоот тогтоолоор “Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”-ыг баталсан.

Тус журамд ТЗК-ийн ХБҮЦ гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдох дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах, сонирхлын зөрчлийг илрүүлэх арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна. Үнэт цаасжуулах үйл ажиллагааны хүрээнд дараах эрсдэлүүд учирч болзошгүй гэж үзэж хэрхэн удирдах арга замын тодорхойлов. Үүнд:

#### Хүснэгт 36: ХБҮЦ-ны хүрээнд учирч болзошгүй эрсдэлүүд

Эрсдэлийн тодорхойлолт	Эрсдэлийн удирдлага
<b>Зээлийн эрсдэл</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Зээлийн эрсдэлд зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх эрсдэлийг ойлгоно. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, Зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.</li> <li>Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэлд зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдах, гооцооллоогүй сул эх үүсвэр үүсэхийг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ТЗК нь зээлтэй холбоотой эрсдэлийг бууруулахын тулд СЗХ-с баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-г мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.</li> <li>Эрсдэлийн сан байгуулах: ТЗК нь дээрх журмын дагуу зээлийн эрсдэлийн санг тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.</li> <li>ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.</li> <li>ТЗК нь зээл хугацаагаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна</li> <li>Зээлийн гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэх бөгөөд тус өөрчлөлт нь шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй тохиолдолд зээлүүдийг зээлийн багцаас хасаж, шалгуур хангах зээлээр солих эсхүл буцаан худалдах нөхцөлтэй.</li> </ul>






### Хөрөнгийн багцтай холбоотой эрсдэл

- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график нь үнэт цаасны төлбөрийн графикаас зөрүүтэй байх эрсдэл
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүдэд өөрчлөлт оруулсантай холбоотой Хөрөнгийн багц чанаргүйдэх эрсдэл
- Тааварлаагүй хүчин зүйл, байгалийн гамшиг зэргээс үүдэн хөрөнгийн багцад байгаа зээлийн фидуциар барьцаалсан хөрөнгөд хохирол, эвдрэл учрах зэрэг эрсдэлийг ойлгоно.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-нд тусгасны дагуу зээлийн багцын эргэн төлөлт болон үнэт цаасны эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийг нэмэгдүүлэх, шаардлага хангаагүй зээлүүдийг солих, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах арга хэмжээ авна.
- 2022 онд МХБ-ээр дамжуулж олон нийтэд санал болгосон Бэрс ХБҮЦ: 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаас харахад 2022 оны жилийн эцсээс хойш багцын хэмжээ 4% буурсан бөгөөд тус зээлүүдийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид тухай бүр буцаан шилжүүлж, шалгуур хангах зээлээр сольж ажиллаж байна. Харин онцлох өөрчлөлтүүд нь: багц дахь зээлийн жигнэсэн дундаж хүү өссөн, зээлүүдийн хугацаа нэмэгдсэн, зээлдэгчийн сарын дундаж орлого нэмэгдсэн зэрэг эерэг өөрчлөлтүүдтэй байна. Түүнчлэн чанаргүй зээлийн хувь 0.42%-аас 0.16% болж буурсан байна. 9-р сард үндсэн төлбөрийн 50 хувийг эргүүлэн төлсөн.
- 2023 онд МХБ-ээр дамжуулж олон нийтэд санал болгосон Бэрс-2 ХБҮЦ: 2023 оны улирлын үйл ажиллагааны тайлангаас харахад 4 зээл буцаан шилжүүлж, 61 зээл багцад нэмж бүртгэсэн байна. Багц дахь зээлүүдийн жигнэсэн дундаж хүү буурсан бол хугацаа өссөн. Тайлангаас харахад өмнөх зээлээс өндөр дүнтэй зээлийг багцад шинээр бүртгэсэн ажиглагдаж байна. Хөрөнгийн багц дахь зээлүүдийг ХИУ нь АҮГ-тай сар бүр тооцоо нийлж, баталгаажуулан ажиллаж байна.
- Зээлийн багцын шалгуур үзүүлэлтэд Фидуцийн барьцааны гэрээний зүйл нь тээврийн хэрэгслийн даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх шалгуурыг оруулж өгсөн.

### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл

- Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь
- Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн эрсдэл үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана. Энэхүү танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар АҮГ-ийн





- хэсэгт заасан зээл шилжүүлэх
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болох
  - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдах зэрэг эрсдэлийг ойлгоно.
- үнэт цаасжуулаагүй автомашины фидуцийн зээлийн хөрөнгийн багц нь үнэт цаасжуулсан хөрөнгийн багцаас 1.6 дахин их байгаа нь солих, сонгох арга хэмжээг авахад хангалттай хүрэлцэхүйц байна.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.
  - ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”, “Фидуцийн барьцааны гэрээ”-нд холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан.
  - ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, бусад нэмэлт үүрэг байхгүй, хөрөнгийн багцад байгаа зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй болохыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч баталгаа гаргасан ба ХБҮЦ-ны туршид уг баталгааг хангаж ажиллана.

**Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл**

- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх
- Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг хорооноос цуцлах
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй, татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.
- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн нэр дээрх харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчтэй зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ байгуулна. ХИУ нь Төлбөр цуглуулах дансны гүйлгээний хуулга авах, хянах эрхтэй.
- Үйлчилгээ үзүүлэгчийн буруутай үйлдлийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.
- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.
- Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь





төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.

- ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-с цуцлах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.
- ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

### Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл

- ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай
- ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй



**Bers ABS**  
loyalty

Үнэт цаасны танилцуулга

холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэлийг ойлгоно.

- Монгол улсын макро эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн зээлдэгчдийн зээл авах эрэлт өөрчлөгдөх
- Хүүгийн түвшин өөрчлөгдсөнөөс үүдэн зээлдэгчдийн зээлийн ачаалал, дарамт нэмэгдэх, эсвэл зээлийг урьдчилж хаах хүсэл нэмэгдэх

холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.

- Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд дараах арга хэмжээг авч ажиллана.
- Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан давагдашгүй хүчин зүйлийг, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.
- Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх ч үндсэн үүргээс чөлөөлөхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хүү болон зээлийн хөрөнгийн багцын хүүгийн хэмжээ тогтмол байх ба үнэт цаасны танилцуулга бэлтгэгдэх үед арилжаа банкнуудын хадгаламжийн хүүтэй харьцуулахад өндөр байгаа бөгөөд бусад нээлттэй өрийн хэрэгслийн хүүгийн хэмжээтэй өрсөлдөхүйц хэмжээнд байна. Хөрөнгө оруулагчдын хувьд хүүгийн төлбөрийг улирал бүр, үндсэн төлбөрийг жилд 1 удаа хүлээн авах ба эзэмших хугацааны туршид дахин хөрөнгө оруулалт хийж хүүгийн түвшиний эрсдэлийг бууруулах боломжтой байна.






**АРВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД  
ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД**

---



**Bers ABS**  
loyalty



**10. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД**

**Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг томилгох тухай**

Үнэт цаас гаргагчийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/26а/07 тоот ТУЗ-ийн тогтоолын дагуу үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг томилсон байна. Тус тогтоолын дагуу Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийг, хөндлөнгийн зээлийн шинжилгээ гаргагчаар “Си Пи Ти Эй Аудит” ХХК -ийг, хөрөнгө Итгэмжлэн Удирдагч байгууллагаар “Юү Эй Эф Ассет Менжмент” ХХК-ийг, Андеррайтераар “Голомт Капитал ҮЦК” ХХК-г тус тус сонгосон байна. ТУЗ-ийн тогтоолыг хавсралтаас харна уу.

**10.1. Андеррайтер**



**Голомт Капитал ҮЦК**

Улсын бүртгэлийн дугаар	9011287134
Регистрийн дугаар	5481589
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.05.19
Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Номинал дансаар дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлэх, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк плэйс оффис, 403 тоот;
Утас	7012-1530
Веб хуудас	<a href="http://www.golomtcapital.com">www.golomtcapital.com</a>
Цахим хаяг	<a href="mailto:info@golomtcapital.com">info@golomtcapital.com</a>
Гүйцэтгэх захирал	С.Ган-Эрдэнэ
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Нөмөр Кредит ассет ХБҮЦ Бэрс-2 ХБҮЦ Бичил 2 ХБҮЦ (синдикатор)

Андеррайтертай байгуулсан гэрээ:

Голомт Капитал ҮЦК нь 2023 оны 10 сарын 09-ны өдөр 23/81 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагчтай байгуулсан. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Андеррайтер нь Үнэт Цаас Гаргагчид МХБ-с 15.0 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлагатай магадлан шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг танилцуулах, санал болгох, арилжих үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэхээр заасан. Түүнчлэн ТЗК-ийн тусгай зөвшөөрөл авсны дараа буюу 2023 оны 11 дүгээр 16-ны өдөр 23/81-1 тоот “Андеррайтерийн үйлчилгээний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ”-ээр ТЗК нь гэрээний оролцогч тал болж нэмэлт гэрээ байгуулсан.







СЭЖ  
УРГАТЭВ  
2023.12.22

ТЗК нь үнэт цаас гаргах, түүний танилцуулга бэлтгэх, олон нийтэд хувьцааг санал болгох, хөрөнгө оруулагч татах үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэхийг Андеррайтераас шаардах эрхтэй. Мөн түүнчлэн үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авч, үр дүнд өөрийн зүгээс санал өгөх, Андеррайтераас санал болгосон хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, мөн тухайн хөрөнгө оруулалтыг хүлээн авахаас татгалзах эрхтэй. Гэрээний бүрэн эхийг хавсралтаас үзэж танилцана уу.

## 10.2. Зээлийн шинжилгээ гаргагч



### “СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ” ХХК

Улсын бүртгэлийн дугаар	9018001113
Регистрийн дугаар	5530121
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.11.08
Үйл ажиллагааны чиглэл	Аудитын үйл ажиллагаа эрхлэх
Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 45А байр Оршил төв 5 давхар 501 тоот
Утас	7723-3030
Веб хуудас	cptaaudit.mn
Цахим хаяг	<a href="mailto:info@cptaaudit.mn">info@cptaaudit.mn</a>
Ерөнхий захирал	Л.Энхчимэг
ХБҮЦ дээр ажилласан туршлага	-


“Си Пи Ти Эй Аудит” ХХК нь анх 2011 онд нягтлан бодох бүртгэл болон татварын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр байгуулагдаж, 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн бол 2023 оны байдлаар тус компани нь 15 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Зээлийн санхүүгийн шинжилгээ хийх гэрээ:

“Бэрс финанс ББСБ” ХХК нь сонгогдсон зээлийн данснууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар “Си Пи Ти Эй Аудит” ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр “Зээлийн санхүүгийн шинжилгээ хийх гэрээ” мастер гэрээ, 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр “Хавсралт I гэрээ” байгуулсан байна. Гэрээгээр гэрээт ажлын цар хүрээ буюу сонгогдсон зээлийн хувийн хэргийг харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу хянаж, харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гүйцэтгэл болон илрүүлсэн асуудлуудыг нэгтгэж тайлагнах асуудлыг зохицуулжээ. Аудитын байгууллага нь Монгол улсын хууль тогтоомж болон Олон улсын стандарт 4400 “Харилцан тохиролцсон ажил үйлчилгээ”-нд нийцүүлэн гэрээт ажлыг гүйцэтгэнэ.

Энэхүү гэрээгээр ажлын хамрах хүрээ, зээлийн шалгуур, хязгаарлалт, шинжилгээний ажлын тайланг хүргүүлэх хугацаа, үйлчилгээний хөлс, бизнес үйл ажиллагааны ерөнхий нөхцөл буюу талуудын хүлээх хариуцлага, үйлчилгээний төлбөр зэрэг бусад харилцааг зохицуулсан байна.






**Bers ABS**  
loyalty

### 10.3. Хуулийн фирм



### Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХНН



Регистрийн дугаар	5495997
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.07.06
Үйл ажиллагааны чиглэл	Хууль зүйн зөвлөгөө өгөх
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал тауэр 13 давхар 1301
Утас	(11) 330048
Веб хуудас	<a href="http://www.mdsa.mn">www.mdsa.mn</a>
Цахим хаяг	<a href="mailto:info@mdsa.mn">info@mdsa.mn</a>
Удирдах гишүүн	Д.Дүгэржав
ХБҮЦ дээр ажилласан туршлага	ЛэндМН актив ХБҮЦ Бэрс ХБҮЦ Инвескор Актив ХБҮЦ МИК актив 1-13, 21, 23, 24, 28, 29 Бэрс-2 ХБҮЦ Бичил 2 ХБҮЦ

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ:

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах, Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгох хүрээнд төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, байгуулсан гэрээ, гэрээний төслүүд нь хүчин төгөлдөр, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргаж, үнэт цаасны холбогдох зөвшөөрөл авах асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, багцын хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлж, хөрөнгийн багцад шинжилгээ хийж, тайлан гаргуулахаар Бэрс Финанс ББСБ ХХК нь "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-тэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 10-р сарын 09-ний өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, гэрээт ажил, гэрээний хугацаа, гэрээт ажлын хөлс хуулийн зөвлөхийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, харилцах хүмүүс, хариуцлагын хязгаарлалт, гэрээг дуусгавар болгох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бусад зүйл гэсэн 11 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2023 оны 11-р сарын 25-ны өдрийн Д-23/336 тоот Автомашинны фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн данснуудын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний тайлан, 2023 оны 11-р сарын 17-ны өдрийн Д-23/341 тоот "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-аас автомашинны фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгохтой холбогдуулан бэлтгэсэн Хууль зүйн дүгнэлтийг тус тус гаргасан.

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг хавсаргасан ба Хууль зүйн дүгнэлт нь Үнэт цаасны танилцуулгын хамт эх хувиар хүргэгдэнэ.



## 10.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч



### “ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЖМЕНТ” ХХК

Регистрийн дугаар  
Үүсгэн байгуулагдсан огноо  
Үйл ажиллагааны чиглэл  
Тусгай зөвшөөрөл авсан огноо

2870657  
2005.01.27  
Хөрөнгө итгэмжлэн удирдах  
2021.10.28

Хаяг

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний  
10 давхарт 1005 тоот

Утас

7012-2346

Веб хуудас

[www.uaf.mn](http://www.uaf.mn)

Цахим хаяг

[info@uaf.mn](mailto:info@uaf.mn)

Гүйцэтгэх захирал

Х.Маргад-Эрдэнэ

ХБҮЦ дээр ажилласан  
туршлага

Омни актив ХБҮЦ  
Симпл ассет ХБҮЦ  
Бэрс ХБҮЦ  
Нөмөр кредит ассет ХБҮЦ  
ЛэндМН актив ХБҮЦ  
Бичил Глобус ХБҮЦ  
Бэрс-2 ХБҮЦ  
Бичил 2 ХБҮЦ

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээ:

“Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК, “Юү Эй Эф Ассет Менжмент” ХХК нарын хооронд 2023 оны 11-р сарын 16-ны өдөр 23/756 тоот “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” байгуулагдсан байна. Тус гэрээ нь гэрээний тусгай нөхцөл, гэрээний ерөнхий нөхцөл, хавсралтаас бүрдсэн байна. Гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх буюу Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багцыг итгэмжлэн удирдах, Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх, Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээний хөлс төлөх холбоотой харилцааг зохицуулсан байна.


Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч компаниудтай ашиг сонирхлын зөрчилгүй болно. Түүнчлэн ХБҮЦ нь олон тооны бага дүнтэй зээлээс бүрдсэн тул зээлийн багцын орох урсгал болон үнэт цаасны төлөлтийн хяналтыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь программ ашиглан хэрэгжүүлнэ. Зээлийн багцын мэдээлэл болон, эргэн төлөлтийн хуваарь, таамаглал дээр үндэслэн Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны мөнгөн урсгал болон, ТЗК-ийн санхүүгийн төсөөллийг гаргасан.

Мөн Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь СЗХ-ноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан байна. Холбогдох баримт бичгийг хавсралтаас харна уу.





**Bers ABS**  
loyalty




### 10.5. Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бэрс Финанс ББСБ" ХХК нарт холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд эдгээр байгууллага нь Үнэт цаас гаргагч "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бэрс Финанс ББСБ" ХХК нартай аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөрөөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

1. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч "Юэ Эй Эф Ассет Менжмент" ХХК
2. Зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК
3. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН
4. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Голомт Капитал ҮЦК" ХХК

Оролцогч байгууллагууд нь бизнесийн нэгдмэл сонирхол, холбоо хамааралгүй талаарх албан бичгүүдийг хавсралтаас харна уу.






2023 07 25

БҮРТҮҮЭГ-03



## ХАВСРАЛТ (үргэлжлэл)

---






## II. ХАВСРАЛТ

<b>II. ХАВСРАЛТ</b>	122
11.1 Үнэт цаас гаргагчийн гэрчилгээ	124
11.2 Үнэт цаас гаргагчийн дүрэм	126
11.3 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	133
11.4 Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах тухай ТУЗ-ийн тогтоол	138
11.5 Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ийн гэрээ, журам батлах тухай ТУЗ-ийн тогтоол	141
11.6 Үнэт цаас гаргагчийг байгуулсан эх үүсвэрийн тухай	142
11.7 Үнэт цаас гаргагчийн ТУЗ томилсон тухай шийдвэр	143
11.8 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн танилцуулга, мэдээлэл	145
11.9 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн баталгаа	153
11.10 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн компанийн засаглал, чадамжийн гэрчилгээ	172
11.11 Үнэт цаас гаргагчийн эхлэлийн баланс	180
11.12 Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө	188
11.13 Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулах тухай шийдвэр	190
11.14 Гарын үсэг зурах эрх бүхий этгээд	193
11.15 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагчийн гэрчилгээ	194
11.16 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагчийн дүрэм	196
11.17 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тусгай зөвшөөрөл	202
11.18 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн тухай	207
11.19 Үүсгэн байгуулагчийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	209
11.20 Үүсгэн байгуулагчийн аудит хийлгэсэн жилийн эцсийн санхүүгийн тайлан	211
11.21 Хөрөнгийн багц дахь хуулийн дүгнэлт	240
11.22 Хөрөнгийн багц дахь зээлийн шинжилгээний тайлан	263
11.23 Хуулийн фирмтэй байгуулсан гэрээ	274
11.24 Хуулийн фирмийн гэрчилгээ	283
11.25 Хуулийн фирмийн тусгай зөвшөөрөл	285
11.26 Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан мастер гэрээ	286
11.27 Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан нэмэлт гэрээ	289
11.28 Зээлийн шинжилгээ гаргагчийн гэрчилгээ	296
11.29 Зээлийн шинжилгээ гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	298
11.30 Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээ	300
11.31 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гэрчилгээ	313
11.32 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрөл	315





11.33	Андеррайтертай байгуулсан үндсэн гэрээ .....	320
11.34	Андеррайтертай байгуулсан нэмэлт гэрээ .....	332
11.35	Андеррайтерийн гэрчилгээ.....	334
11.36	Андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ.....	336
11.37	Фидуцийн барьцааны гэрээ .....	341
11.38	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ .....	364
11.39	Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ .....	371
11.40	Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ.....	378
11.41	Үнэт цаас гаргагчийн программ хангамж түрээсээр ашиглах гэрээ .....	383
11.42	Ажлын байрны түрээсийн гэрээ.....	393
11.43	Хөрөнгө итгэмжлэн удирдах журам .....	398
11.44	Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам	404
11.45	Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам .....	410
11.46	Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам .....	416
11.47	Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих журам .....	419
11.48	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам .....	424
11.49	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх журам .....	430
11.50	Андеррайтерийн тодорхойлох захидал .....	433
11.51	Хэлцэлд оролцогч талуудын сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл.....	438

